




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР



ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2014 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2014

УЛААНБААТАР ХОТ 2015 он


**ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР
ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2014 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН**

Хянан тохиолдуулсан:	Р.Ганхуяг ГХГЗЗГ-ын Кадастрын хэлтсийн дарга
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	П.Нямдаваа ГХГЗЗГ-ын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн
Тайлан гаргасан:	Г.Баяржаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн Х.Оюунбаяр – КХ-ийн мэргэжилтэн Э.Сансарбаяр – КХ-ийн мэргэжилтэн Э.Эрдэнэбаяр – КХ-ийн мэргэжилтэн П.Баянтүмэн – КХ-ийн мэргэжилтэн П.Нямдаваа – КХ-ийн мэргэжилтэн Д.Болормаа – ГЗБХ-ийн ахлах мэргэжилтэн С.Дэнсмаа – ГЗБХ-ийн мэргэжилтэн Ц.Ихбаяр – ГЗБХ-ийн мэргэжилтэн Н.Мөнхөө – ГЗБХ-ийн мэргэжилтэн П.Гэрлээ – ГЗБХ-ийн мэргэжилтэн М.Оргил – ГЗБХ-ийн мэргэжилтэн З.Мөнхзаяа – ГЗБХ-ийн мэргэжилтэн Р.Отгончимэг – ССМХ-ийн мэргэжилтэн Д.Очгэрэл – ССМХ-ийн мэргэжилтэн Б.Билгүүн – ЗХШХ-ийн ахлах мэргэжилтэн С.Энх-Эрдэнэ – ЗХШХ-ийн мэргэжилтэн



АГУУЛГА

Оршил	4
1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	5
1.1. Газрын нэгдмэл сангийн удирдлага, менежмент.....	5
1.1.1. Нийслэл, дүүргийн газрын алба	6
1.1.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрууд.....	7
1.1.3. Сумдын газрын даамлууд.....	11
1.2. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт	15
1.3. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа	20
1.4. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал	22
1.5. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан	25
1.6. Газрын зах зээлийн тойм.....	30
1.7. Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан	35
1.8. Газрын кадастрын судалгаа, хэмжил, зураглал гүйцэтгэсэн талаар.....	42
1.9. 2014 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	43
1.9.1. Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилт.....	43
1.9.2. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтийн хэрэгжилт	46
2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН	50
2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ–1, 5/.....	50
2.1.1. Хөдөө аж ахуйн газар.....	52
2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар.....	54
2.1.3. Зам, шугам сүлжээний газар	55
2.1.4. Ойн сан бүхий газар.....	56
2.1.5. Усны сан бүхий газар.....	57
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ–4/	57
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ–2/.....	60
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ–3/.....	63
2.5. Газарт учруулсан хохирлын тайлан /Маягт ГТ–6/.....	66
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ–7/	72
2.7. Газрын төлбөр ногдуулалт, төлөлт /Маягт ГТ–8/	75
2.8. Газар өмчлөлийн тайлан /Маягт ГТ–9/.....	86
3. ДҮГНЭЛТ	90
Хавсралт /тайлангийн ГТ1 –ГТ9 маягт/.....	92



ОРШИЛ

Монгол улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол улсын “Газрын тухай хууль”-ийн 26 дугаар зүйлийн 2.6–д заасан билээ. Уг заалтын дагуу аймаг, нийслэлийн 2014 оны газрын нэгдмэл сангийн тайланг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1–ГТ9 маягтын дагуу нэгтгэн танилцуулж байна.


Газрын нэгдмэл сангийн тайлан нь тайлангийн хугацаанд газрын ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрт гарсан өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой.

ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

1

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 09 дүгээр тушаалаар Нэгдсэн удирдлага, хамтын ажиллагааны алба, Газар зохион байгуулалтын алба, Геодези, зураг зүйн алба, Суурь судалгаа, мониторингийн алба, Кадастрын алба, Орон зайн мэдээлэл, технологийн алба, Хот төлөвлөлтийн алба, Санхүү, хяналт шинжилгээний алба гэсэн нийт 8 алба, 1 Мэдээллийн төв гэсэн бүтцийн 9 нэгж, нийслэлийн өмчийн харилцааны газар, дүүргийн өмч, газрын харилцааны алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна /Зураг 1.1.1/.


1.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖМЕНТ



Нийслэл, дүүрэг, 21 аймгийн газрын асуудал эрхэлсэн газар, алба, сумдын газрын даамал

Зураг 1.1.1 Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын бүтэц

Газрын салбарт агентлагт 68, нийслэл, дүүргийн Газрын албанд 208, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 355, суманд Газрын даамал 344, нийт 975 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.1.2/.



Зураг 1.1.2 Улсын хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчид


Агентлаг нь ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллалаа.

Мөн агентлагийн алба, хэлтсүүд, мэргэжилтнүүд, орон нутгийн харьяа байгууллага, газрын мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг холбогдох чиглэлээр тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр тогтмол өгч ажилласан ба агентлагаас 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчид болон сумдын газрын даамлуудын судалгааг авч Газрын нэгдмэл сангийн хүний нөөцийн тайланг өмнөх онуудаас илүү дэлгэрэнгүй байдлаар нэгтгэн гаргалаа.

Судалгааг ерөнхий мэдээлэл, боловсрол, туршлага, нийгмийн хамгаалал гэсэн 4 бүлэг, нарийвчилсан 26 мэдээлэл бүхий хүснэгтээр гаргасан болно.


1.1.1. Нийслэл, дүүргийн газрын алба

Нийслэлийн хэмжээнд газрын салбарт 208 албан хаагч ажиллаж байгаагаас 48% нь эрэгтэй 52% нь эмэгтэй албан хаагч байна /Зураг 1.1.1.1/.



Зураг 1.1.1.1 Нийслэлийн хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн харьцаа

Насны ангиллын хувьд 76% нь 22–40 насныхан, 24% нь 41–ээс дээш насныхан байгаа бөгөөд 50–иас дээш насны 19 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.1.1.2/.



Зураг 1.1.1.2 Нийслэл, дүүргийн газрын албаны албан хаагчдын насны ангилал


Нийслэл, дүүргийн газрын албаны нийт 208 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 190, Төрийн үйлчилгээний албан хаагч 18 байна. Төрийн захиргааны 190 албан хаагч нь зэрэглэлийн хувьд ТЗ–5–аас ТЗ–9 хүртэл байна /Зураг 1.1.1.3/.



Зураг 1.1.1.3 Нийслэл, дүүргийн газрын алба албан тушаалын ангилал

21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудад ажиллаж байгаа албан хаагчдыг насны байдлаар ангилж үзвэл:


Нийт албан хаагчдын 70% нь 18–40 насны, 30% нь 40 ба түүнээс дээш насныхан байгаа ба үүнээс 51 албан хаагч 50–иас дээш настай байна /Зураг 1.1.2.1/.



Зураг 1.1.2.1 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын насны харьцуулалт


1.1.2 Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрууд

Нийт албан хаагчдын 55% нь эрэгтэй, 45% нь эмэгтэй албан хаагчид байгаа ба 83% нь тухайн орон нутгийн уугуул иргэд ажиллаж байна /Зураг 1.1.2.2/.



Зураг 1.1.2.2 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын хүйсийн харьцаа болон тухайн орон нутгийн уугуул иргэн эсэх


Албан хаагчдын 66% нь төрийн албанд 1–ээс 15 жил ажиллаж байгаа бөгөөд 15–аас дээш 36 жил хүртэл ажиллаж байгаа 63 /нийт албан хаагчдын 17%/ албан хаагч байна /Зураг 1.1.2.3/.



Зураг 1.1.2.3 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын төрийн албанд мэргэшсэн байдал жилээр


Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт 355 албан хаагчдаас Төрийн захиргааны албан хаагч 239, Төрийн үйлчилгээний албан хаагч 98, гэрээт ажилтан 15 байна. Гэрээт ажилтныг ихэнхи тохиолдолд Нэг цонхны үйлчилгээн

дээр авч ажиллуулж байна. Төрийн захиргааны 239 албан хаагч нь зэрэглэлийн хувьд ТЗ–5–аас ТЗ–9 хүртэл байгаа бөгөөд эдгээрийн 120 нь буюу нийт албан хаагчдын 34% нь төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй, хууль тогтоомжийн дагуу үндсэн цалингаас гадна зэрэг дэвийн нэмэгдэл авдаг байна /Зураг 1.1.2.4/.



Зураг 1.1.2.4 Албан тушаалын ангилал, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй эсэх


Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын нийт албан хаагчдын 73% нь бакалаврын зэрэгтэй, 12% буюу 42 албан хаагч магистрын зэрэгтэй, 15% буюу 52 албан хаагч бүрэн болон тусгай дунд боловсролтой байна. Бүрэн болон тусгай дунд боловсролтой албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн үйлчилгээний албан үүргийг гүйцэтгэж байна. /Зураг 1.1.2.5/




Зураг 1.1.2.5 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын боловсролын түвшин

Ажлын байранд шаардагддаг програм хангамжийг нийт албан хаагчдын 56 хувь нь бүрэн болон сайн эзэмшсэн, давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 182, орос хэлний мэдлэгтэй 120, бусад хэл буюу Солонгос, Герман, Хятад хэлний мэдлэгтэй 6 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.1.2.6/.

ArcGis, AutoCad, LM /ажлын байранд шаардагддаг программ хангамжийг эзэмшсэн байдал/




Гадаад хэлний мэдлэг



Зураг 1.1.2.6 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын ур чадвар


Нийт албан хаагчдын 54 хувь нь буюу 183 албан хаагч эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 83 хувь нь буюу 286 албан хаагч банк болон санхүүгийн байгууллагад тодорхой хэмжээний зээлтэй байна /Зураг 1.1.2.7/.

Эзэмших, ашиглах өмчлөх эрхийн газартай эсэх



● Тийм ● Үгүй

Банк болон санхүүгийн байгууллагад зээлтэй эсэх



● Тийм ● Үгүй


Зураг 1.1.2.7 Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын албан хаагчдын нийгмийн асуудал

21 аймгийн нийт 330 суманд 344 газрын даамал ажиллаж байгаа бөгөөд ажлын онцлогоос шалтгаалж цөөн тооны суманд 2 газрын даамал ажиллаж байна.

Сумдын газрын даамлуудыг нас болон хүйсээр нь харьцуулан авч үзэхэд: нийт газрын даамлуудын 50% нь 21–30 насныхан, 32% нь 30–40 насныхан байгаа ба 18 хувь нь 40 ба түүнээс дээш насны албан хаагчид ажиллаж байна. 50–иас дээш насны 26 газрын даамал ажиллаж байна.

Нийт албан хаагчдын 89% нь тухайн орон нутгийн уугуул иргэд байна /Зураг 1.1.3.1, 1.1.3.2/.


1.1.3 Сумдын газрын даамлууд



Зураг 1.1.3.1 Сумдын газрын даамлуудын насны ангилал


Хүйсийн харьцаа

Тухайн орон нутгийн уугуул иргэн эсэх




Зураг 1.1.3.2 Сумдын газрын даамлуудын хүйсийн харьцаа, тухайн орон нутгийн уугуул иргэд эсэх

Газрын даамлуудын 75% нь төрийн албанд 1–ээс 15 жил ажиллаж байгаа ба 2014 онд томилогдсон 47 албан хаагч байна. 50 албан хаагч буюу 14% нь төрийн албанд 15–аас дээш 28 жил хүртэл ажиллаж байна /Зураг 1.1.2.3/.




Зураг 1.1.3.3 Сумдын газрын даамлуудын төрийн албанд мэргэшсэн байдал /жилээр/

Төрийн албан хаагчийн ангиллын хувьд 100% төрийн захиргааны албан хаагчид бөгөөд ТЗ–З зэрэглэлтэй байна. Эдгээрийн 128 газрын даамал нь буюу 37% нь төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй, хууль тогтоомжийн дагуу үндсэн цалингаас гадна зэрэг дэвийн нэмэгдэл авдаг байна /Зураг 1.1.3.4/.




Зураг 1.1.3.4 Сумдын газрын даамлуудын албан тушаалын ангилал, зэрэг дэвийн харьцуулалт

Сумдын газрын даамлуудыг орон тооны, мэргэжлийн ажилтнуудтай болгох асуудлыг анхааран ажилласны үр дүнд 71% нь мэргэжлийн орон тооны ажилтан болсон байна. /Зураг 1.1.3.5/ Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулвал 9%–иар нэмэгджээ.




Зураг 1.1.3.5 Сумдын газрын даамлууд мэргэжлийн байдал

335 газрын даамал бакалаврын зэрэгтэй /нийт газрын даамлуудын 97%/, магистрын зэрэгтэй 3, бүрэн болон тусгай дунд боловсролтой 4 газрын даамал ажиллаж байна /Зураг 1.1.3.6/.




Зураг 1.1.3.6 Сумдын газрын даамлуудын боловсролын түвшин

Давхардсан тоогоор англи хэлний мэдлэгтэй 195, орос хэлний мэдлэгтэй 47, бусад хэлний мэдлэгтэй 2 газрын даамал байна. Сумдын газрын даамлуудын 92% нь буюу 317 газрын даамал ажлын байранд шаардагдах програм хангамжийг тодорхой хэмжээгээр эзэмшсэн ба үүнээс 15 нь бүрэн, 214 нь сайн, 88 нь дунд хэмжээгээр эзэмшсэн байгаагаас харахад цаашид улам мэргэшүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна /Зураг 1.1.3.7/.



Зураг 1.1.3.7 Сумдын газрын даамлуудын мэргэшсэн байдал, ур чадвар

Нийт албан хаагчдын 52% нь буюу 165 газрын даамал эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн газартай, 77% буюу 253 албан хаагч банк болон санхүүгийн байгууллагаас эзэлтэй байна /Зураг 1.1.3.8/.



Зураг 1.1.3.8 Сумдын газрын даамлуудын нийгмийн асуудал

Сумдын газрын даамлууд төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн хувьд ТЗ–3–т хамааран цалинжиж байгаа нь тэдний гүйцэтгэдэг ажил үүрэгтэй нь харьцуулахад хэт бага байгаа юм. Иймд сумын газрын даамлын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ТЗ–5 зэрэглэл болгон өөрчлөх шаардлагатай байна.

Мөн цаашид албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

1.2. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2014 онд улсын хэмжээнд Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт болон дотоод ажилд хийсэн 778 удаагийн хяналт, шалгалтаар нийт 4545 зөрчил илэрсэн байна.


Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалтын тоо, хэмжээ улсын хэмжээнд 2013 онд өмнөх оныхтой харьцуулахад 1020 удаа буюу 6,5%-иар өссөн дүнтэй байсан бол 2014 онд уг хяналт, шалгалтын тоо 778 буюу 2013 онтой харьцуулахад 23,8%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол (Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай) батлагдсаны дагуу хөдөө орон нутагт холын сумд руу явах томилот, зардал багассантай холбоотой хяналт шалгалтын болон илэрсэн зөрчлийн тоо буурсан байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 9 дүүрэгт хяналт шалгалт хийснээс нийт 539 зөрчил дутагдал илэрсэн байна. Дээрх зөрчлийн ихэнх хувийг хууль бусаар газар эзэмшүүлсэн, мөн “Газрын тухай хууль”-ийн 21.5.3, 29.1, 31.3, 33.1.2, 34.2 дэх заалтууд буюу Дүүргийн ИТХ-аас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байх; шинээр олгосон газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцахгүй байх; хуулиар олгосон хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлтийг дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэх; аж ахуйн нэгж, байгууллагууд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсний дараа газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ авах гэсэн хуулийн тус тус заалтууд зөрчигдсөн байх тул иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр 1000 м²-аас дээш хэмжээ бүхий газар эзэмшүүлэх, эрх олгох, баталгаажуулах тухай захирамжуудыг хуулбарлан Нийслэлийн Өмчийн харилцааны газраар хянуулж байх мөн дээрх зөрчлийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах тухай албан даалгаврыг дүүргүүдийн Өмч, газрын харилцааны албадуудад хүргүүлж ажилласан байна.


Харин орон нутагт аймгуудын ГХБХБГ, сумын Газрын даамал бусад холбогдох албан тушаалтнуудтай хамтарч хийсэн хяналт шалгалтаар эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан, хоёр жил дараалан ашиглаагүй, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй байгаа зөрчил ихэнх хувийг эзэлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад газар эзэмшиж, ашиглах талаар хуулийн мэдлэг мэдээллийг өгөх, сурталчилахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

2014 онд Баян-Өлгий, Ховд, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Архангай аймгууд хяналт шалгалтыг олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумуудаа хамруулж 50–104 удаа явуулсан байна.


Нийслэлийн Өмчийн харилцааны газар болон дүүргийн Өмч, газрын харилцааны албадууд хүн амын нягтрал болон газрын эрэлт хэрэгцээ шаардлага ихтэй, газрыг эдийн засгийн эргэлтэд байнга оруулдаг зэрэг нөхцөл байдлын үүднээс газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хяналт шалгалтыг тогтмол, олон удаа хийхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.



Зураг 1.2.1: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажилдхийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо



Зураг 1.2.2: 2010–2014 онд Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо болон илэрсэн зөрчил



Зураг 1.2.3: Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчлийн тоо

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил 2014 онд 48 болж өмнөх оныхоос 59,2%–иар буурсан байна.

2014 онд Газрын үйл ажиллагааны талаар хийсэн шинэлэг ажлын хувьд зарим аймаг, дүүргүүд сайшаалтай тодорхой ажлуудыг хийсэн байна. Тухайлбал Нээлттэй Засаг хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн дүүргүүдийн Өмч, газрын харилцааны албадуудад мэдээллийн ил тод байдал, газрын харилцааны чиглэлээр үзүүлдэг үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилготой угтах үйлчилгээг дүүргүүдэд ажиллуулж байна. Мөн иргэдэд үзүүлдэг үйлчилгээний эмх цэгц, түргэн шуурхай байдлыг хангах зорилготой цахим дугаарлалтыг Сонгинохайрхан дүүргийн Өмч, газрын харилцааны албанаас эхлэн нэвтрүүлсэн байна.

Дундговь аймгийн хувьд аймгийнхаа Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллах төлөвлөгөө гарган 11 суманд 120 иргэний газар болон үл хөдлөх эд хөрөнгийг кадастрын зурагт оруулсан байна. Завхан аймаг Газрын харилцааны байгууллага үүсч хөгжсөний 60 жилийн ойг тохиолдуулан “Хуулийн хэрэглээ” номыг гарын авлага болгон хэвлүүлж нийтийн хүртээл болгосон байна.

Баянхонгор аймагт 2014 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрдэнэмандал багийн нутагт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар жишиг хороолол бий болгох зорилгоор иргэдэд газрыг үнэгүй өмчлүүлэн нэгдсэн журмаар хашаа хатган эрүүл ахуй, эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, тоглоомын талбай, усан сангийн газрыг төлөвлөж иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчилж ая тухтай орчин бүрдүүлж өгсөн нь урд жилүүдийн газар олголтыг бодвол онцлог давуу талтай ажил болсон байна.

Увс аймагт аймгийн Засаг даргын захирамжаар 10–р багийн нутаг дэвсгэрт хуулийн дагуу 2 жил дараалан ашиглаагүй үндэслэлээр 886,7 м³ газрыг хураан авч нийтийн биеийн тамирын талбайг барьж ашиглалтад оруулсан ажил хийгдсэн байна.

Баян–Өлгий аймагт шинээр газар олголтын асуудлыг багийн Засаг дарга болон иргэний оролцоотой шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Мөн 2014 онд орон нутгийн харьяа нэгжүүдэд хяналт шалгалтыг зөвхөн хууль тогтоомжийн хэрэгжилтээр биш аймаг, нийслэлийн буюу орон нутаг дахь нэгжийн дотоод ажил, зохион байгуулалтын асуудлыг дүгнэхээр тайлангийн үзүүлэлтүүдээ

өөрчлөн аймаг, нийслэлийг дундаж оноогоор дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын хэрэгжилт 9.3;
- Ажилтнуудын үр дүнгийн гэрээ дүгнэсэн байдал 9.5;
- Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээ, зохион байгуулсан ажил 9.5;
- Ажилтнуудын ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэх хуудас бөглөсөн байдал 9.7;
- Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаж буй байдал, хадгалалт 9.8;
- Батлагдсан ажлын байрны тодорхойлолтод нийцсэн мэргэжлийн хүн авч ажиллуулсан байдал 8.7;
- Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, түүний хувь эргэлтийн судалгааг гаргасан байдал 9.4;
- Албан бичгийн бүрдэл, стандартын дагуу боловсруулсан байдал 9.6;
- Тамга тэмдэг, хэвлэмэл хуудсын хадгалалт, хамгаалалт, ашиглалт 9.8 оноотойгоор тус тус дүгнэгдсэн байна.

Дээрх үзүүлэлтүүдээс батлагдсан ажлын байрны тодорхойлолтод нийцсэн мэргэжлийн хүн авч ажиллуулсан байдал 8.7 оноотой дүгнэгдсэн байх бөгөөд орон нутагт ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангасан мэргэжил, мэдлэг ур чадвартай ажилтан авч ажиллуулахад анхаарах шаардлагатай байна.

2014 онд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас 6 ажлын хэсэг байгуулан 20 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 40 сумдад ажиллан Газар зохион байгуулалт, кадастр, геодези, хууль, эрх зүйн чиглэлийн сургалт зохион байгуулж, газрын тухай хууль, тогтоомж, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ийн хэрэгжилт, Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.


Дээрх ажлын удирдамжийн дагуу ажлын хэсэг аймаг, сумын Засаг дарга, сумын газрын даамал, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт мэргэжлийн хэлтсүүдээс /хуучнаар/ өгсөн зөвлөмжөөс гадна Захиргаа, хүний нөөц, дотоод ажилдаа хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах үүднээс дараах зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэхдээ батлагдсан тогтоол журмыг баримталж ажиллах
2. Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсэгт газрын болон барилгын мэргэжлийн чиглэлээс 2–3 хүн оролцуулах
3. Албан тушаалын жагсаалт батлах тушаал гаргах
4. Ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал бүрээр нягтлан шалгаж, батлах
5. Албан тушаалын жагсаалтын дагуу ажилтнуудыг томилсон тушаал гаргах

6. Албан тушаалын ангилал, зэрэглэлийг зөв болгох
7. Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөх
8. Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын талаарх хяналт шалгалтыг бүх сумуудаа хамруулан хийх
9. Дотоод ажлыг бодитой дүгнэж, дүгнэсэн үндэслэл, хийсэн ажлын дэлгэрэнгүй тайлангаа хавсаргах
10. Газрын үйл ажиллагааны талаар тулгамдаж байгаа асуудлаа шийдвэрлэсэн, үр дүнтэй ажил зохион байгуулан ажиллах
11. Газрын багц хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг сурталчилж ажиллах.

1.3. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

Улсын хэмжээнд 2014 онд газар ашиглах, эзэмших, эзэмшиж байгаа газраа өмчлөх, шинээр өмчлөх эрхтэй холбогдон ирүүлсэн өргөдөл хүсэлтийн судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 159033 өргөдөл хүсэлт ирүүлсэнээс шинээр газар эзэмших 36988 /22.26%/, шинээр газар ашиглах 2967 /1.87%/, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 5897 /3.71%/, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 6196 /3.9%/, газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах 6517 /4.1%/, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах 900 /0.57%/, эзэмшиж байгаа газраа өмчлөх 8552 /5.38%/, өмчилсөн газрынхаа хэмжээг өөрчлөх 3425 /2.15%/, өмчилсөн газраа барьцаалах 2865 /1.8%/, шинээр газар өмчлөх 80177 /50.42%/, өмчлөх эрхээ шилжүүлэх 3555 /2.24%/, өргөдөл хүсэлт ирүүлжээ.



Зураг 1.3.1: Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлын судалгаа




Улсын хэмжээнд нийт 159033 өргөдөл хүсэлт ирснээс 134702 /84.7%/ өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. 24331 /15.3%/ өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэгдээгүй байна. Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь дараах байдалтай байна. Үүнд:

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргасан,
- Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдсанаас хойш материалаа ирүүлсэн,
- Бичиг баримтын зөрчилтэй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон,
- Нисэхийн хориотой бүсэд, үерийн аман дээр газар ашиглах, эзэмших, өмчлөх, зөвшөөрөлгүй газар дээр газар ашиглах,
- Тусгай хамгаалалттай газарт орсон зэрэг хүсэлт гаргаснаас болж шийдвэрлэх боломжгүй байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй түүнчлэн шинээр эзэмшүүлэх болон өмчлүүлэх газрын нөөц бага, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байна.

I.4. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2014 онд газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбогдон гарсан маргааны судалгааг нэгтгэн дүгнэхэд нийт 2089 маргаан гарснаас газар эзэмшихтэй холбоотой 1385 /68%, газар өмчлөхтэй холбоотой 535 /26%, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн 93 /4%, газар ашиглахтай холбоотой 73 /3%/ маргаан тус тус гарснаас 1613 газрын маргааныг шийдвэрлэж хариу өгөөд байна / Зураг I.4.1/.



Зураг I.4.1: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал

Гарч буй зөрчил, маргааныг авч үзвэл газар эзэмших эрхтэй холбоотой дараах маргаан давамгайлж байна:

- Зөвшөөрөлгүй хашаагаа сунгах;
- Нийтийн эзэмшлийн талбайг зөвшөөрөлгүй ашиглах;
- I давхрын өргөтгөл хийх;
- Газар эзэмшүүлэх гэрээний нөхцлөө зөрчих;
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй;
- Хашааг эзэмшил газрын хэмжээнээс хэтрүүлэн барьсан;
- Газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй;
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;
- Газрыг давхардуулан эзэмшүүлэх.

Шийдвэрлэгдээгүй 234 маргаан үлдсэн бөгөөд гол шалтгаан нь үл хөдлөх хөрөнгийн холбогдолтой тул шүүхийн шийдвэрийг хүлээх, мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулах, мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааныг Засгийн газраас томилогдсон холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтийг хүлээх зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 1.4.1: Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал аймаг, нийслэлээр/

№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
						Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	30	47	2	0	24	38	1	0	6	9	1	0
2	Баянхонгор	21	23	11	0	11	12	6	0	10	11	5	0
3	Баян-Өлгий	177	29	3	50	167	21	2	45	8	1	6	5
4	Булган	21	2	2	0	18	2	0	0	1	0	0	0
5	Говь Алтай	52	17	13	1	38	6	7	1	14	11	6	0
6	Говьсүмбэр	9	8	1	0	0	8	1	0	0	0	0	0
7	Дархан-Уул	47	50	1	0	41	49	0	0	6	1	1	0
8	Дорнод	8	11	0	0	6	10	0	0	0	0	1	0
9	Дорноговь	5	3	8	0	5	3	8	0	0	0	0	0
10	Дундговь	26	19	1	0	23	15	0	0	3	1	4	0
11	Завхан	495	22	0	0	197	22	1	0	244	0	0	0
12	Орхон	65	85	0	0	65	85	0	0	0	0	0	0
13	Өвөрхангай	46	8	10	0	39	7	6	0	7	1	4	0
14	Өмнөговь	3	17	0	0	3	17	0	0	0	0	0	0
15	Сүхбаатар	4	16	0	0	4	14	0	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	35	21	3	19	31	18	3	19	4	0	5	0
17	Төв	65	85	0	0	65	85	0	0	0	0	0	0
18	Увс	35	21	10	0	32	21	10	0	3	0	0	0
19	Ховд	73	41	4	3	49	36	3	0	24	5	1	3
20	Хөвсгөл	28	4	2	0	28	4	1	0	10	0	1	0
21	Хэнтий	49	11	3	0	40	4	1	0	1	4	2	0
22	Улаанбаатар	158	14	9	0	126	10	2	0	32	7	4	0
Дүн		1452	551	75	73	1012	484	44	65	373	51	41	8

Тус онд ГХГЗЗГ-т бүх шатны шүүхээс болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөлд хариу өгсөн байдлыг дүгнэхэд шинжээчийн дүгнэлт 64 болж өмнөх оноос 2.3 дахин, тайлбар нотолгоо 151 болж өмнөх оноос 2.8 дахин өссөн байна.

Мөн Засгийн газрын “11–11 төв”-өөс ирүүлсэн 256 өргөдөлд хариу өгсөн байна.

Газрын маргаан гарах үндсэн шалтгаан нь Газартай холбоотой хууль, тогтоомж, журам, зааврын хэрэгжилт болон түүнд тавих хяналт хангалтгүй байх, албан тушаалтны санаатай болон санаандгүй үйлдэл, шийдвэр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн болон бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтын газарт үйл ажиллагаа явуулах, хашаа барих зэргээс үйдэлтэй байна.

Цаашид газрын зөрчлийг гарсан хойно нь шийдвэрлэх, арилгах тал дээр ихээхэн хөрөнгө мөнгө, хугацаа зарцуулахын оронд маргаан зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаар тодорхой судалгаа, дүн шинжилгээ хийх гарч буй шалтгаанаар нь ангилж бүртгэн, гарах үр дагаврыг тооцон урьдчилан сэргийлж газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, мөрдүүлэх нээлттэй ил тод болгох, мөн зөрчил, маргааныг иргэдэд чирэгдэл багатай доод шатандаа шийдвэрлэдэг болох, ингэснээр шүүхээр дамжуулан шийдвэрлэдэг маргааны тоог бууруулах боломжтой юм.

Мөн орон нутгийн газрын асуудал хуриуцсан бүх шатны байгууллагууд газрын кадастрын дэс дараалсан үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, журам, зааврын дагуу хийх, газартай холбоотой шийдвэр гаргагчид болон иргэд, олон нийтэд дээрх хууль, тогтоомж, журам, зааврын уялдаа, холбоо болон өмчийн эрх зүйн ач холбогдлыг таниулан, ойлгуулах чиглэлээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.5. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасан ба газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан билээ.


“Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8–д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”–д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасан байдаг.

Тус заалтыг үндэслэн жил бүр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Өмч газрын харилцааны газар, дүүргийн Өмч газрын харилцааны алба, сумын Газрын даамал газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэдэг ба бүртгэлийг жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргадаг билээ.

Дээрх бүртгэлээс харахад 2014 онд улсын хэмжээнд 9221 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба дээрх бүртгэлийг улсын хэмжээнд нэгтгэн 2012, 2013 оны дүн мэдээтэй харьцуулав. /Хүснэгт 1.5.1., Зураг 1.5.1./

Хүснэгт 1.5.1. Газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал /2012–2014 он/.

Д/д	Аймаг, нийслэл	2012 он	2013 он	2014 он
1	Архангай	73	155	298
2	Баян-өлгий	1795	1940	533
3	Баянхонгор	181	334	1040
4	Булган	315	438	231
5	Говь-Алтай	1703	2461	386
6	Говь-Сүмбэр	56	52	61
7	Дархан-Уул	190	469	1283
8	Дорнод	158	291	102
9	Дорноговь	160	237	352
10	Дундговь	78	148	57
11	Завхан	216	246	114
12	Орхон	352	376	136
13	Өвөрхангай	437	628	317
14	Өмнөговь	329	312	185
15	Увс	934	1242	970
16	Сүхбаатар	345	177	488
17	Сэлэнгэ	915	1010	882
18	Төв	137	475	524
19	Ховд	126	140	393
20	Хөвсгөл	2214	1374	615
21	Хэнтий	205	194	156
22	Нийслэл	0	0	913
Нийт		10919	12699	9221



Зураг 1.5.1. Газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдал /2012–2014 он/.

Аймагуудын 2013 оны болон 2014 оны барьцааны бүртгэлийг харьцуулахад урьд оныхоос 27.3 хувиар буурч 33478 болжээ. Харин улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 30702 Монгол улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба нийт 39455 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол улсын нийт нэгж талбарын 5.6 хувь нь барьцаалагдсан байна.

2014 онд газар эзэмших эрхийн гэрчилгээгээ болон өмчийн газраа барьцаалсан байдлыг улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.5.2, зураг 1.5.2-д үзүүлэв.


Аймгуудын 2013 оны болон 2014 оны барьцааны бүртгэлийг харьцуулахад урьд оныхоос 27.3 хувиар буурч 33478 болжээ. Харин энэ онд нийслэлийн Өмчийн харилцааны газраас газар эзэмших эрхээ барьцаалсан бүртгэлийг ирүүлсэн нь улсын хэмжээнд нэгтгэх боломжтой болж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 30702 Монгол улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан ба нийт 39455 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол улсын нийт нэгж талбарын 5.6 хувь нь барьцаалагдсан байна.

2014 онд газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлыг улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.5.2, зураг 1.5.2-д үзүүлэв.

Хүснэгт 1.5.2. Газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдал /2014 он/

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	405	298	107
2	Баян-Өлгий	1340	533	807
3	Баянхонгор	2041	1040	1001
4	Булган	745	231	514
5	Говь-Алтай	635	386	249
6	Говьсүмбэр	209	61	148
7	Дархан-Уул	1283	468	815
8	Дорнод	562	102	460
9	Дорноговь	493	352	141
10	Дундговь	266	57	209
11	Завхан	719	114	605
12	Орхон	1153	136	1017
13	Өвөрхангай	2065	317	1748
14	Өмнөговь	1248	185	1063
15	Увс	1759	970	789
16	Сүхбаатар	787	488	299
17	Сэлэнгэ	2648	882	1766
18	Төв	1567	524	1043
19	Ховд	1459	393	1066
20	Хөвсгөл	1286	615	671
21	Хэнтий	1051	156	895
22	Нийслэл	16202	913	15289
ДҮН		39923	9221	30702




Зураг 1.5.2. Газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдал /2014 он/

2014 онд газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлаас харахад ихэнхи буюу 60% нь Хаан банкинд, 36% нь Төрийн банк, Голомт банк, Хас банк, Капитал банк, Худалдаа хөгжлийн банкинд, үлдсэн 4% нь буюу бусад гэсэн ангилалд Капитрон банк, Ариг банк, Улаанбаатар хотын банк, Чингис хаан банк, ХХАХҮЯ-ны Мал хамгаалах сан, Аймгийн ЗДТГ-ын Жижиг дунд үйлдвэрийн газарт барьцаалсан байна /Хүснэгт 1.5.3, Зураг 1.5.3./ Гэвч 9221 газар эзэмших эрх нь зөвхөн үл хөдлөх хөрөнгөтэй хамт барьцаанд тавигдсан ба дангаараа барьцаа болох боломж бүрдэхгүй байсаар байна.

Хүснэгт 1.5.3. Газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсан байдал.

№	Аймаг, нийслэл	Эзэмших эрхээ барьцаалсан	Барьцаалагчийн нэр						
			Хаан банк	Төрийн банк	Голомт банк	Хас банк	Капитал банк	Худалдаа хөгжлийн банк	Бусад
1	Архангай	298	142	137	1	14	4	0	0
2	Баян-Өлгий	533	259	86	29	110	42	5	2
3	Баянхонгор	1040	600	210	16	128	86	0	0
4	Булган	231	155	6	1	46	1	2	20
5	Говь-Алтай	386	353	4	0	29	0	0	0
6	Говьсүмбэр	61	19	10	0	31	0	1	0
7	Дархан-Уул	468	235	87	16	22	5	51	52
8	Дорнод	102	33	6	6	20	8	25	4
9	Дорноговь	352	169	9	9	84	40	28	13
10	Дундговь	57	26	5	0	18	0	1	7
11	Завхан	114	73	24	0	13	0	1	3
12	Орхон	136	52	24	7	5	10	21	17
13	Өвөрхангай	317	199	52	8	44	1	6	7
14	Өмнөговь	185	75	35	14	27	8	13	13
15	Увс	970	791	32	2	139	5	0	1
16	Сүхбаатар	488	393	37	16	41	1	0	0
17	Сэлэнгэ	882	341	252	14	145	20	44	66
18	Төв	524	473	3	3	6	2	1	36
19	Ховд	393	370	4	0	10	8	0	1
20	Хөвсгөл	615	389	30	10	148	34	2	2
21	Хэнтий	156	109	7	2	36	1	1	0
22	Нийслэл	913	239	33	104	109	30	277	121
ДҮН		9221	5495	1093	258	1225	306	479	365



Зураг 1.5.3. Газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад барьцаалан санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж буй хугацааны хувьд дундажаар 3 жил байна. Энэ нь одоогоор харьцангуй богино хугацаа боловч цаашдаа иргэний өмчийн газрыг урт хугацаагаар барьцаалж ипотекийн зээл олгох боломж харагдаж байгаа юм.

1.6. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойшхи эдийн засгийн хурдацтай хөгжил нь өмч, тэр дундаа газрыг татвар, төлбөрийн, барьцаат зээллэгийн, арилжааны, дуудлага худалдааны, хөрөнгө оруулалтын, нөхөн олговрын, шүүхийн, шинжээчийн, судалгааны зэрэг олон зориулалтаар мэргэжлийн үүднээс үнэлэх шаардлага, эрэлтийг бий болгосоор байна.

Тиймээс Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын 2011 оны 182 тоот тушаалаар “Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах заавар, маягт”- ыг батлан хэрэгжүүлж байгаа билээ.


Газрын татвар, төлбөрийг зах зээлийн бодит үнэнд ногдуулах, дуудлага худалдааны анхны үнэ, барьцаа зээлийн үнэ, нөхөн олговрын үнэ, худалдан борлуулах үнийг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн бодитойгоор тогтоох зорилгоор дээрх заавар, маягтын дагуу аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Өмч газрын харилцааны газар, дүүргийн Өмч, газрын харилцааны алба, сумын Газрын даамал улирал бүр газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай /ГХ/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай /ХАА/, худалдаа үйлчилгээний зориулалттай /ХҮ/, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай /Ү/ гэсэн 4 төрлөөр цуглуулж байна.

2014 онд улсын хэмжээнд 18964 газар өмчлөх, эзэмших эрх бусдад шилжсэн байна. Үүнээс 4210 газрын зах зээлийн үнийн мэдээг нь цуглуулснаас гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 3825, худалдаа үйлчилгээний зориулалттай 203, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 182, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 0 /үнийн мэдээ ирээгүй/ тус тус байна.

Хүснэгт 1.6.1: Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

Д/д	Аймаг, нийслэл	ГХ		ХҮ		ХАА	Ү
		Байшинтай	Байшингүй	Барилгатай	Барилгагүй		
1	Архангай	97	0	27	0	8	0
2	Баян-Өлгий	65	0	0	0	0	0
3	Баянхонгор	30	0	12	0	0	0
4	Булган	48	14	29	0	32	0
5	Говь-Алтай	69	0	3	0	0	0
6	Говьсүмбэр	13	96	0	0	0	0
7	Дархан-Уул	202	0	2	0	13	0
8	Дорноговь	44	0	9	5	0	0
9	Дорнод	302	0	0	0	0	0
10	Дундговь	55	0	11	0	0	0
11	Завхан	127	0	20	0	0	0
12	Орхон	542	0	0	0	0	0
13	Өвөрхангай	72	59	6	0	0	0
14	Өмнөговь	94	0	0	0	0	0
15	Увс	38	0	12	0	10	0
16	Сүхбаатар	40	0	0	0	0	0
17	Сэлэнгэ	101	0	17	0	81	0
18	Төв	29	33	0	0	0	0
19	Ховд	0	0	0	0	0	0
20	Хөвсгөл	83	112	26	0	25	0
21	Хэнтий	72	0	24	0	13	0
22	Нийслэл	1,362	0	0	0	0	0
23	Дүн	3,485	314	198	5	182	0


Зах зээлийн үнийн мэдээний 84.6%–ийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнэ, 9.2%–ийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнэ, 5.7%–ийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнэ, 0.5%–ийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ эзэлж байгаа юм /Зураг 1.6.1/.



Зураг 1.6.1: Газрын зах зээлийн үнийн мэдээний эзлэх хувь

Гэр бүлийн зориулалттай газар

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 3825 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дундажаар 827 м² талбатай газар 11 сая 500 мянган төгрөгөөр худалдагдсан ба 1 м² газрын дундаж үнэ 20584 төгрөг байна /Зураг 1.6.2/.




Зураг 1.6.2: Гэр бүлийн хэрэгцээний м² газрын дундаж үнэ

Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 м² газрын дундаж үнэ Булган, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт 32000–35000 төгрөг, Баян–Өлгий, Дундговь, Дорнод, Завхан, Өмнөговь, Увс, Төв, Хөвсгөл, Хэнтий аймагт 10000–30000 төгрөг, Говь–Алтай, Дархан–Уул, Дундговь, Орхон аймагт 3700–10000 төгрөг тус тус байна.

Харин Улаанбаатар хотын хувьд 2013 онд гэр бүлийн хэрэгцээний 1 м² газрын дундаж үнэ 60803 төгрөг байсан бол 2014 онд 39380 төгрөг болсон байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 198 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дунджаар 763 м² талбайтай газар 22 сая 209 мянган төгрөгөөр худалдагдсан ба 1 м² газрын дундаж үнэ 133991 төгрөг байна / Зураг 1.6.3/.



Зураг 1.6.3: Хөрөнгө оруулалт хийгдсэн худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 м² газрын дундаж үнэ

Худалдаа үйлчилгээний зориулалттай 1 м² газрын дундаж үнэ Баянхонгор, Булган, Дархан–Уул, Дорноговь, Дундговь, Увс, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймагт 100000–340000 төгрөг, Архангай, Говь–Алтай, Завхан, Өвөрхангай аймагт 57000–100000 төгрөг тус тус байна.


ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 182 мэдээ цуглуулаад байна. Эдгээр цуглуулсан үнийн мэдээнээс харахад төмс, хүнсний ногоо тариалах зориулалттай газар болон үр тариа тариалах зориулалттай газрын зах зээлийн үнийн мэдээ байгаа улсын 1 га газрын дундаж үнэ 2 сая 228 мянган төгрөг байна. Үүнээс үзэхэд манай улсад хөдөө аж ахуйн газрын зах зээл хөгжиж байгаа нь харагдаж байгаа юм.

Улсын хэмжээнд 2014 оны байдлаар 803217 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгдсэн ба үүнээс 58767 нь буюу 7.5 хувь нь газрын зах зээлийн харилцаанд оржээ /Хүснэгт 1.6.2, Зураг 1.6.4/.

Хүснэгт 1.6.2: Газар өмчлөгч, эзэмшигийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс			Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан	Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлгэлсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2013	19686	11034	8652	34349	6790	4744	22815
2014	14742	5521	9221	44025	8341	4982	30702



Зураг 1.6.4: Газар өмчлөгч, эзэмшигийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

2014 онд 10126 га газар буюу нийт газар нутгийн ойролцоогоор 0.006 хувь нь эдийн засгийн эргэлтэнд оржээ. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 523 тэрбум 943 сая төгрөг болж байна.

Монгол улсын ДНБ 21 их наяд 844 тэрбум төгрөг ба газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн хэмжээ ДНБ-ний 2.4% эзэлж байна.

Үүнээс үзэхэд Монгол улсын нийт үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэж, газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, газрын зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бий болговол ДНБ-ний хэмжээг өсгөх нөөц боломж байгаа нь харагдаж байна.

Хэдийгээр ДНБ-д газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн эзлэх хувь нэмэгдэж байгаа ч Монгол улсад газар эзэмших, ашиглах эрхийг нягтлан бодох бүртгэлд өмч гэж үзэж бүртгэхгүй байсаар байна.

Иймд улсын хэмжээнд газрын суурь үнийг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн тогтоож, зах зээлийг нээлттэй уян хатан болгосноор газраас хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Үүнийг бүрдүүлэхийн тулд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан 1 га газрын суурь үнийг хувийн өмчийн газрын харилцаа үүсэн бий болж байгаа өнөөгийн нөхцөлд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, одоогийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тогтоож Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлээ.

**1.7. ГАЗРЫН
ДУУДЛАГА
ХУДАЛДАА,
ТӨСӨЛ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН
ТАЛААРХ МЭДЭЭ,
ТАЙЛАН**

“Газрын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 33.1.1–д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3–т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно. Мөн 44.4. Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ” гэж тус тус заасан байдаг.

Дээрх заалтуудыг үндэслэн Засгийн газрын 2003 оны 02 дугаар сарын 07–ны өдрийн “Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 7 дугаар хавсралтаар “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ыг тус тус батлан одоог хүртэл дагаж мөрдөж байгаа билээ.

Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоол болон ЗТБХБ /хуучин нэрээр/-ын Сайдын 2010 оны 206 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-ын дагуу тодорхойлдог.

Дээрх журам аргачлалыг ашиглан 2014 онд улсын хэмжээнд 725 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулан 7599.4 га газрыг эзэмшүүлжээ.

Хүснэгт 1.7.1: 2014 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал.

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа явуулсан тоо	Талбай		Төсөвт орсон орлого / мян.төг/
			/м ² /	/га/	
1	Архангай	61	463960	46.40	56,401.00
2	Баян–Өлгий	0		0	0
3	Баянхонгор	5	4480	0.45	2,192.50
4	Булган	75	8248567	824.86	92,579.46
5	Говь–Алтай	8	47463	4.75	65.18
6	Говьсүмбэр	39	848506	84.85	93,682.18
7	Дархан–Уул	11	49382	4.94	169,042.00
8	Дорноговь	145	6511036.9	651.10	309,538.39
9	Дорнод	27	36516765	3651.68	208,609.83
10	Дундговь	3	5600	0.56	48,204.00
11	Завхан	0	0	0	0
12	Орхон	3	20400	2.04	33,448.50
13	Өвөрхангай	22	399300	39.93	77,738.60
14	Өмнөговь	15	169700	16.97	50,064.60
15	Увс	11	36650	3.67	5,931.30
16	Сүхбаатар	5	4600	0.46	185,500.00
17	Сэлэнгэ	52	1929309	192.93	90,003.77
18	Төв	61	19404380	1940.44	213,881.63
19	Ховд	18	80510	8.05	30,951.84
20	Хөвсгөл	63	550301	55.03	88,686.84
21	Хэнтий	101	703095	70.31	121,939.43
22	Нийслэл	0	0	0	18,223,000.00
ДҮН		725	75994004	7599.40	20,101,461.05

2014 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт 20 тэрбум 101 сая 461 мянган төгрөгийг улсын төсөвт оруулсны дотор нийслэлийн Өмчийн харилцааны газраас 90,5 % буюу 18 тэрбум 223 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба үүнийг урд нь шууд Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн газруудад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг мэдэгдэл, нэхэмжлэлээр нөхөн ногдуулж авсан байна /Зураг 1.7.1/.



Зураг 1.7.1: 2013–2014 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /мян.төг/

2013 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт 27,9 тэрбум төгрөг орсон бол 2014 онд 27 хувиар буурсан байна.

Энэ нь дээр дурьдсан Нийслэлийн Өмчийн харилцааны газраас эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны анхны үнийг мэдэгдэл, нэхэмжлэлээр нөхөн ногдуулж авсантай холбоотой байгаа юм.


Харин 21 аймагт газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар нийт 1 тэрбум 878 сая 461 мянган төгрөгийг улсын төсөвт оруулсан нь 2013 оныхоос 46 хувиар буурчээ /Зураг 1.7.2./.



Зураг 1.7.2: 2013–2014 онд 21 аймагт газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /мян.төг/


Энэ нь тайлант онд 42 газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны ялагч үнэ төлөөгүй улмаас 3 тэр бум 263 сая 719 мянган төгрөг улсын төсөвт ороогүйгээс шалтгаалж байгаа нь харагдаж байна.

2014 онд Дорноговь, Хэнтий, Булган, Хөвсгөл, Архангай, Төв аймгууд хамгийн олон буюу 61-ээс дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан бол Баян-Өлгий, Завхан аймгууд болон Нийслэл газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулаагүй байна. 2013–2014 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав /Зураг 1.7.3/.



Зураг 1.7.3: 2012–2013 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо

Тайлант онд 725 дуудлага худалдаа зохион байгуулснаас 92 удаагийн буюу 12.7 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 50 удаагийн буюу 54.3 хувь нь оролцогчгүй, нэг оролцогч ирсний улмаас хүчингүй болж, 38 удаа дахин зарлажээ. Харин 42 удаагийн буюу 45.7 хувь нь дуудлага худалдааны үнээ төлөөгүйн улмаас буцсан байна /Зураг 1.7.4/.



Зураг 1.7.4: дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь

Мөн дуудлага худалдаанд 2 оролцогч оролцсон тохиолдол 61.4 хувийг эзэлжээ.

Дээрхээс харахад дуудлага худалдааны зар олон нийтэд хүрэхгүй, дуудлага худалдаанд оролцохоор сонирхсон этгээд байрлалаас шалтгаалан оролцож чадахгүй байх, зохион байгуулалттай дуудлага худалдаанд оролцох зэрэг асуудлууд байгаа нь харагдаж байна.

Тиймээс ГХГЗЗГ-аас Засгийн газрын 2003 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг шинэчлэн боловсруулаад байна.

Тус журмын төсөлд дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэхээр дуудлага худалдааны зарыг өргөн хүрээнд зарлах, цахим хэлбэрээр зохион байгуулах, оролцогчоос хамааран хүчингүй болохгүй байх талаарх зохицуулалтуудыг тусгаж өглөө.

2014 онд улсын хэмжээнд 242 удаа газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулан 13475,3 га газрыг эзэмшүүлжээ.


Хүснэгт 1.7.2: 2014 оны төсөл сонгон шалгаруулалтын мэдээ

№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо	Талбай		Төсөвт орсон орлого /мян.төг/
			м ²	га	
1	Архангай	7	17000	1.7	28,800.00
2	Баян-Өлгий	2	65675	6.6	50.00
3	Баянхонгор	6	26140	2.6	0
4	Булган	5	30034000	3003.4	0
5	Говь-Алтай	3	281110	28.1	9,931.10
6	Говьсүмбэр	1	1500	0.2	0
7	Дархан-Уул	53	6237000	623.7	0
8	Дорноговь	51	8447893	844.8	90,131.71
9	Дорнод	3	8230000	823.0	99,000.00
10	Дундговь	0	0	0	0
11	Завхан	0	0	0	0
12	Орхон	26	108411	10.8	0
13	Өвөрхангай	9	1482	0.1	0
14	Өмнөговь	6	10100	1.0	200.00
15	Увс	4	40000	4.0	0
16	Сүхбаатар	0	0	0	0
17	Сэлэнгэ	1	1600	0.2	1,440.00
18	Төв	35	7100000	710.0	0
19	Ховд	1	1200	0.1	0
20	Хөвсгөл	0	0	0	0
21	Хэнтий	29	74150638	7415.0	0
22	Нийслэл	0	0	0	0
ДҮН		242	134753749	13475.3	229552.812

Улсын хэмжээнд Дархан-Уул, Дорноговь, Төв, Хэнтий, Орхон, аймгууд хамгийн олон буюу 26-аас дээш газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан бол Дундговь, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд болон Нийслэлд газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй байна. 2013-2014 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулж харуулав. /Зураг 1.7.5/.




■ 2013 он
■ 2014 он



Зураг 1.7.5: 2013–2014 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо

2014 онд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо 2013 оноос 4 дахин нэмэгдэж 242 төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулснаас 18 удаагийн буюу 7.4 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ. /Зураг 1.7.6/.



Зураг 1.7.6: Төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн эзлэх хувь

Мөн төсөл сонгон шалгаруулалтанд 1 төсөл ирүүлсэн тохиолдол 40.1 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн онд Нийслэл, Завхан, Баян-Өлгий аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрээр газар эзэмшүүлэхийг түр хугацаагаар зогсоосонтой холбоотойгоор газрын эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Аймгуудаас ирүүлсэн тайлангаас үзэхэд дуудлага худалдааны ялагчийн 67.6 хувь нь иргэн байгаа бол үлдсэн 32.4 хувь нь аж ахуйн нэгж ялагч болсон байна. Харин төсөл сонгон шалгаруулалтын 53.7 хувь нь аж ахуйн нэгж үлдсэн 46.3 хувь нь иргэн ялагч болжээ.


**1.8. ГАЗРЫН
КАДАСТРЫН
СУДАЛГАА,
ХЭМЖИЛ,
ЗУРАГЛАЛ
ГҮЙЦЭТГЭСЭН
ТАЛААР**

Улсын хэмжээнд 2013 онд 472171 нэгж талбар улсын бүртгэлд бүртгэгдсэн ба 2014 оны жилийн эцсийн байдлаар 517578 нэгж талбар болж 45407-аар нэмэгдсэн байна.

Нийслэлийн хэмжээнд кадастрын зургийг тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ууд, аймгуудийн хэмжээнд 68% ийг аймгийн ГХБХБГ 32% ийг тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ууд кадастрын зураглалыг гүйцэтгэж байна.

Хүснэгт 1.8.1: Кадастрын өөрчлөлтийн тайлан /тоо/

№	Кадастрын зураглалын өөрчлөлт	2013	2014	Зөрүү
1	Кадастрын зурагт орсон хуучин байсан нэгж талбар	433223	517578	84355
2	Шинээр нэмэгдсэн нэгж талбар	35271	39702	4431
3	Нэмэгдсэн нэгж талбар	33007	35580	2573
4	Нийт нэгж талбар	472171	509930	37759
5	Шинээр орсон барилга	11160	9852	1308
6	Нийт барилга	316937	346764	29827
7	Нийт цэгийн тоо	4352	5145	793
8	Өмнөх онд бүртгэгдсэн цэг, тэмдэгтийн тоо	4391	4864	473
9	Утсан цэгийн тоо	118	158	40



- Нийт нэгж талбар
- Шинээр орсон барилга
- Нийт барилга
- Нийт цэгийн тоо
- Өмнөх онд бүртгэгдсэн цэг, тэмдэгтийн тоо
- Утсан цэгийн тоо
- Кадастрын зурагт орсон хуучин байсан нэгж талбар
- Шинээр нэмэгдсэн нэгж талбар
- Нэмэгдсэн нэгж талбар

Зураг 1.8.1: Кадастрын өөрчлөлт


Аймаг, нийслэл, сум, дүүрэгт 2014 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг ГХГЗЗГ-ын даргын 2010 оны 497 тоот тушаалаар батлагдсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”, мөн 2010 оны 589 тоот тушаалаар батлагдсан “Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулж, хэрэгжүүлсэн байна.

Аймаг, нийслэлд 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сум, дүүрэг бүрээр боловсруулж хэрэгжүүлсэн бөгөөд аймаг, нийслэлийн хэмжээнд хот тосгон, бусад суурин газар болон хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргалаа.

1.9. 2014 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хот тосгон, бусад суурин газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээ, аялал жуулчлал, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлэх, гадаадын иргэн харьяалалгүй хүн, хуулийн этгээд болон уул уурхайн зориулалтаар газар ашиглуулах, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх, уул уурхайн газарт нөхөн сэргээлт хийх, газрын зөрчил, маргааныг шийдвэрлэх, газар хамгаалах, нөхөн сэргээх зэрэг нийт 18 төрлийн ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Хот суурин газарт төлөвлөсөн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Говьсүмбэр, Говь-Алтай, Дорноговь аймгууд 76–80 хувиар хэрэгжүүлж тэргүүлсэн байна /Зураг 1.9.1.1/.




1.9.1. Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөний хэрэгжилт

Зураг 1.9.1.1: Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөлтийн хэрэгжилт /хувь/

Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Төв аймгууд хот суурин газарт газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах талаар хамгийн олон ажил төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Харин Орхон, Сүхбаатар, Баян-Өлгий аймгууд бусад аймгуудтай харьцуулахад цөөн ажил төлөвлөжээ.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлын хүрээнд:

Улсын хэмжээнд 23098.1 га газар гэр бүлийн хэрэгцээнд шинээр өмчлүүлэхээр төлөвлөснөөс 4230.84 га газар өмчлүүлж, хэрэгжилт 18.3 хувьтай байна. Баян-Өлгий, Орхон аймгууд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан хэмжээнээс 532.6 га-аар хэтрүүлэн өмчлүүлсэн байна /Зураг 1.9.1.2/.



Зураг 1.9.1.2: Хот тосгон, бусад суурин газарт өмчлүүлсэн газрын хэмжээ, зориулалт /га/


Эзэмшиж байгаа хашааны 2355.1 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 1142.1 га газар өмчлүүлсэн ба хэрэгжилт 48.5 хувьтай байна. Баянхонгор, Баян-Өлгий, Увс аймгууд болон Улаанбаатар хотод газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшиж байгаа хашааны газрыг өмчлүүлэхээр тусгасан газрын хэмжээг 202.7 га-аар хэтрүүлэн өмчлүүлсэн байна.

Улсын чанартай зам дагуу 1096.2 га газар өмчлүүлэхээр төлөвлөснөөс 555.1 га газрыг өмчлүүлж хэрэгжилт 50.6 хувьтай байна. Тухайн жилд Дундговь, Булган аймгууд тэргүүлсэн байна.

Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь өмчлүүлэхээр 16 га газар төлөвлөснөөс 0.4 га газар өмчлүүлж, хэрэгжилт 2.6 хувьтай байна.

Газар эзэмшүүлэх ажлын хүрээнд:


Улсын хэмжээнд 24249.9 га газар хот суурин газарт эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 14191.3 га газар эзэмшүүлж, хэрэгжилт 59 хувьтай байна. Тухайн жилд хэрэгжилтээрээ Говьсүмбэр, Говь-Алтай аймгууд тэргүүлж байна. Харин Дундговь, Орхон аймгууд төлөвлөгөөнд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 19.1 га-г, Архангай, Дархан-Уул, Завхан, Увс аймгууд гэр бүлийн хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 69.7 га-г, Дархан-Уул аймаг гэр бүлийн хэрэгцээнд хүнсний ногоо тариалах зориулалтаар газар эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 29.8 га газар хэтрүүлэн эзэмшүүлсэн байна /Зураг 1.9.1.3/.



Зураг 1.9.1.3: Хот тосгон, бусад суурин газарт эзэмшүүлсэн газрын хэмжээ зориулалт /га/

Газар ашиглуулах ажлын хүрээнд:

Улсын хэмжээнд 11747,7 га газар хот суурин газарт ашиглуулахаар төлөвлөснөөс 8552,1 га газар ашиглуулсан байна. Уул уурхайн зориулалтаар ашиглуулсан газрын хэмжээ бусад зориулалтаар ашиглуулсан газрын хэмжээнээс өндөр үзүүлэлттэй байна. Өмнөговь аймагт уул уурхайн зориулалтаар 188,2 га газар ашиглуулахаар төлөвлөснөөс 207 га газар ашиглуулж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаас 18.8 га-гаар хэтрүүлэн ашиглуулсан байна /Зураг 1.9.1.4/.




Зураг 1.9.1.4: Хот тосгон, бусад суурин газарт ашиглуулсан газрын хэмжээ, зориулалт /га/

1.9.2. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтийн хэрэгжилт


Хөдөө аж ахуйн газарт өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, бэлчээр зохион байгуулалт, тариалан, хадлангийн газрыг эзэмшүүлэх, хамгаалах, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар газар эзэмшүүлэх, ой, усны сан бүхий газрыг хамгаалах, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах зэрэг нийт 26 төрлийн ажил төлөвлөж хэрэгжүүлэв.

Булган, Сэлэнгэ, Төв аймгууд бусад аймгуудаас олон төрлийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Говьсүмбэр, Орхон, Хэнтий аймгууд төлөвлөсөн ажлын хэрэгжилтээр тэргүүлж байна. Завхан аймаг хөдөө аж ахуйн газарт ямар нэгэн ажил төлөвлөөгүй байна /Зураг 1.9.2.1/.



Зураг 1.9.2.1: Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөөний хэрэгжилт /тоо, хувь/

Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг бэлчээр зохион байгуулалт, хөдөө аж ахуйн газарт эзэмшүүлсэн, ашиглуулсан болон газар хамгаалах, нөхөн сэргээх талаар төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээгээр бүлэглэн үзүүлэв /Зураг 1.9.2.2/.




Зураг 1.9.2.2: Бэлчээрийн газарт төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээ /га/

Өмнөх онтой харьцуулахад сум, багийн хэмжээнд бэлчээрийн газрыг хамгаалах, сайжруулах талаар малчид ард иргэдтэй хамтран олон арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэв. Үүний үр дүнд 837287,9 га бэлчээрийг сайжруулж, ашиглалтгүй бэлчээрт шинээр 409 худаг гаргахаар төлөвлөснөөс 276 худаг гаргаж, 278 худаг засварлахаар төлөвлөснөөс 246 худаг засварласан байна.


Увс, Дорнод аймаг аж ахуйн нэгж, байгууллагад 9139,8 га газар эзэмшүүлж тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж санаачлагатай ажилласан байна.

Ховд аймаг мал аж ахуй эрхлэх, хадлан, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал, мод үржүүлгийн зориулалтаар 39 га газар эзэмшүүлсэн нь бусад аймагтай харьцуулахад илүү олон зориулалтаар газар эзэмшүүлэхээр 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлжээ /Зураг 1.9.2.3/.




Зураг 1.9.2.3: Хөдөө аж ахуйн газарт эзэмшүүлсэн газар /га/

Улсын хэмжээнд нийт 275811,1 га газрыг хөдөө аж ахуйн газарт ашиглуулахаар төлөвлөснөөс 425079,1 га газрыг хадлан, эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай тариалангийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулсан байна. Дундговь, Булган аймгууд газар зохион байгуулалтын 535 га газар өвөлжөө, хаваржааны зориулалтаар ашиглуулан тэргүүлж байна. Харин Завхан аймаг болон Улаанбаатар хотын хэмжээнд хөдөө аж ахуйн газарт төлөвлөлт хийгдээгүй байна /Зураг 1.9.2.4/.



Зураг 1.9.2.4: Хөдөө аж ахуйн газарт ашиглуулсан газрын хэмжээ, зориулалт /га/

Тусгай хамгаалалтанд 2652501.9 га газар авахаар төлөвлөснөөс 1950856.8 га газрыг авав /Зураг 1.9.2.5/.



Зураг 1.9.2.5: Газар хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ /га/


2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмнөх онтой харьцуулахад өргөн хүрээг хамарсан, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, зөрчил маргааныг бууруулах, орон нутгийн хөгжил, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн нийт 36 төрлийн арга хэмжээг тусгаж хэрэгжүүлжээ.

2

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

2014 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 115008.6 мянган га буюу 73.53 хувь, хот, тосгон бусад суурины газар 712.1 мянган га буюу 0.46 хувь, зам, шугам сүлжээний газар 454.8 мянган га буюу 0.29 хувь, ойн сан бүхий газар 14320.5 мянган га буюу 9.16 хувь, усны сан бүхий газар 686.7 мянган га буюу 0.44 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 25228.9 мянган га буюу 16.13 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тус бүрийн эзлэх хувь

2013 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 352.8 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 12.5 мянган га, зам, шугам сүлжээний газар 17.5 мянган га, ойн сан бүхий газар 25.1 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 297.8 мянган га-гаар тус тус нэмэгдэж, усны сан бүхий газар 0.1 мянган га-аар хасагдсан байна /Хүснэгт 2.1.1/.


Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү /мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	115361.4	115008.6	-352.8
1	Бэлчээрийн газар	11026.1	110646.7	-379.4
2	Хадлангийн талбай	1712.3	1717.6	5.3
3	Тариалангийн газар	986.8	1012.8	26.0
4	Атаршсан газар	304.9	304.9	0.0
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	71.4	76.8	5.4
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0
II	Хот, тосгон бусад суурины газар	699.6	712.1	12.5
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	73.1	75.3	2.2
8	Нийтийн эдэлбэр газар	330.1	330.3	0.2
9	Үйлдвэрийн газар	40.4	41.1	0.7
10	Уурхайн газар	200.9	206.2	5.3
11	Гэр хорооллын газар	54.5	59.3	4.8
III	Зам, шугам сүлжээний газар	437.3	454.8	17.5
12	Авто замын газар	319.7	329.7	10.0
13	Төмөр замын газар	27.8	29.9	2.1
14	Агаарын тээврийн газар	8.8	8.9	0.1
15	Шугам сүлжээний газар	80.8	86.2	5.4
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
IV	Ойн сан бүхий газар	14295.4	14320.5	25.1
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12138.6	12181.3	42.7
18	Ой модыг нь огтолсон газар	142.4	142.0	-0.4
19	Мод үржүүлгийн газар	46.5	50.9	4.4
20	Ой тэлэн ургах нөөц газар	744.0	743.6	-0.4
21	Ойн сангийн бусад газар	1223.7	1202.7	-21.0
V	Усны сан бүхий газар	686.8	686.7	-0.1
22	Гол мөрний эзлэх газар	228.5	228.5	0.0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	444.7	444.3	-0.4
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.1	1.6	0.5
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	24931.1	25228.9	297.8
26	Улсын тусгай хамгаалалттай газар	20948.3	21140.9	192.6
27	Улсын хилийн зурвас газар	3111.9	3111.9	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	22.9	22.9	0.0
31	Аймаг дундын отрын бэлчээр	586.2	691.4	105.2
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.4	24.4	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
	НИЙТ ДҮН	156411.5	156411.5	0.0

2.1.1. Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 115008.6 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 73.53 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 110646.7 мянган га буюу 96.21 хувь, хадлангийн газар 1717.6 мянган га буюу 1.49 хувь, тариалангийн газар 1012.8 мянган га буюу 0.88 хувь, атаршсан газар 304.9 мянган га буюу 0.27 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 76.8 мянган га буюу 0.07 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.7 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1.1/.



- Бэлчээрийн газар
- Хадлангийн талбай
- Тариалангийн газар
- Атаршсан газар
- ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар
- ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар

Зураг 2.1.1: Хөдөө аж ахуйн газрын ангиллын эзлэх хувь

Хүснэгт 2.1.1: Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	115361.4	115008.6	-352.8
1	Бэлчээрийн газар	111026.1	110646.7	-379.4
2	Хадлангийн талбай	1712.3	1717.6	5.3
3	Тариалангийн газар	986.8	1012.8	26.0
4	Атаршсан газар	304.9	304.9	0.0
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	71.4	76.8	5.4
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.7	1259.7	0.0



Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2013 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 352.8 мянган га-аар хасагдсан байна.

Хадлангийн газар


Хадлангийн газар нь 2013 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 5.3 мянган га-аар нэмэгдсэн байна.

Тариалангийн газар

Тариалангийн газар нь 2013 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 26 мянган га-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлтийн товчоо /га/

№	Аймгийн нэр	2013	2014	Зөрүү /га/
1	Архангай	23726.74	22011.94	-1714.80
2	Баянхонгор	1877.15	2626.25	749.10
3	Баян-Өлгий	1207.40	1101.70	-105.70
4	Булган	71156.49	71156.49	0.00
5	Говь-Алтай	4894.68	4914.88	20.20
6	Говьсүмбэр	381.02	385.52	4.50
7	Дархан-Уул	34634.24	34814.84	180.60
8	Дорноговь	377.50	398.20	20.70
9	Дорнод	87420.59	99540.87	12120.28
10	Дундговь	688.82	689.72	0.90
11	Завхан	1756.77	1756.77	0.00
12	Орхон	4938.00	4546.00	-392.00
13	Өвөрхангай	15712.86	17479.16	1766.30
14	Өмнөговь	815.44	716.13	-99.31
15	Сүхбаатар	14717.71	14717.71	0.00
16	Сэлэнгэ	313979.23	314071.25	92.02
17	Төв	251295.81	255131.40	3835.59
18	Увс	46556.94	51065.10	4508.16
19	Ховд	8164.85	8378.74	213.89
20	Хөвсгөл	33266.68	33440.38	173.70
21	Хэнтий	62205.20	66680.59	4475.39
22	Улаанбаатар	7059.38	7131.36	71.98
Нийт дүн		986833.50	1012754.99	25921.49




Зураг 2.1.1.3: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон бусад суурины газар 712.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.46 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 75.3 мянган га буюу 10.57 хувийг, нийтийн эдэлбэрийн газар 330.3 мянган га буюу 46.38 хувийг, үйлдвэрийн газар 41.1 мянган га буюу 5.77 хувийг, уурхайн газар 206.2 мянган га буюу 28.96 хувийг, гэр хорооллын газар 59.3 мянган га буюу 8.33 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот, тосгон, бусад суурины газрын ангиллын эзлэх хувь


Хүснэгт 2.1.2.1: Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт /мян га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү
II	Хот, тосгон бусад суурины газар	699.6	712.1	12.5
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	73.1	75.3	2.2
2	Нийтийн эдэлбэр газар	330.1	330.3	0.2
3	Үйлдвэрийн газар	40.4	41.1	0.7
4	Уурхайн газар	200.9	206.2	5.3
5	Гэр хорооллын газар	54.5	59.3	4.8

Зам, шугам сүлжээний газар 454.8 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.29 хувийг эзэлж байна.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 329.7 мянган га буюу 72.5 хувийг, төмөр замын доорх газар 29.9 мянган га буюу 6.6 хувийг, агаарын тээврийн газар 8.9 мянган га буюу 1.9 хувийг, шугам сүлжээний газар 86.2 мянган га буюу 18.9 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.

2.1.3. Зам, шугам сүлжээний газар



- Авто замын газар
- Төмөр замын газар
- Агаарын тээврийн газар
- Шугам сүлжээний газар
- Усан тээврийн буудлын газар

Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын ангилал тус бүрийн эзлэх хувь


Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү
III	Зам, шугам сүлжээний газар	437.3	454.8	17.5
1	Авто замын газар	319.7	329.7	10.0
2	Төмөр замын газар	27.8	29.9	2.1
3	Агаарын тээврийн газар	8.8	8.9	0.1
4	Шугам сүлжээний газар	80.8	86.2	5.4
5	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

2.1.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 14320.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.16 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12181.3 мянган га буюу 85.06 хувийг, ой модыг нь огтолсон газар 142 мянган га буюу 1 хувийг, мод үржүүлгийн газар 50.9 мянган га буюу 0.36 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 743.6 мянган га буюу 5.2 хувийг, ойн сангийн бусад газар 1202.7 мянган га буюу 8.4 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.4.1/.



- Ой модоор бүрхэгдсэн газар
- Ой модыг нь огтолсон газар
- Мод үржүүлгийн газар
- Ой тэлэн ургах нөөц газар
- Ойн сангийн бусад газар

Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын ангиллын эзлэх хувь


Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү
IV	Ойн сан бүхий газар	14295.4	14320.5	25.1
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12138.6	12181.3	42.7
2	Ой модыг нь огтолсон газар	142.4	142.0	-0.4
3	Мод үржүүлгийн газар	46.5	50.9	4.4
4	Ой тэлэн ургах нөөц газар	744.0	743.6	-0.4
5	Ойн сангийн бусад газар	1223.7	1202.7	-21.0

Усны сан бүхий газар 686.7 мянган га буюу нийт газар нутгийн 0.44 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 228.4 мянган га буюу 33.27 хувийг, нуур, цөөрөм 444.3 мянган га буюу 64.69 хувийг, горхи, булаг, шанд 12.4 мянган га буюу 1.81 хувийг, мөнх цас, мөсөн гол 1.6 мянган га буюу 0.23 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.5.1/.

2.1.5. Усны сан бүхий газар




Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын ангиллын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газар 25228.9 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 16 хувийг эзэлж байна.

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21140.8 мянган га буюу 84.1 хувийг, улсын хилийн зурвас газар 3112.0 мянган га буюу 13.0 хувийг, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 1.0 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.031 мянган га буюу 0.001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 22.9 мянган га буюу 0.009 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.4 мянган га буюу 2.3 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.4 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.5 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2.1 мянган га буюу 0.008 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.2.1/.

2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/



- Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд
- Улсын хилийн зурвас газар
- Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар
- Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар
- Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай
- Аймаг дундын отрын бэлчээр
- Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай
- Эдийн засгийн чөлөөт бүсийн газар

Зураг 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га-гаар/

Улсын тусгай хэрэгцээний газар 2013 онд 24931.1 мянган га байсан бол 2014 оны эцсээр 25228.9 мянган га газар болон нэмэгдсэн байна. /Хүснэгт 2.2.1/



Хүснэгт 2.2.1: Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2013	2014	Зөрүү
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	24931.1	25228.9	297.7
1	Улсын тусгай хамгаалалттай газар	20948.3	21140.8	192.5
2	Улсын хилийн зурвас газар	3112.0	3112.0	0
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124.1	124.1	0
4	Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар	0.031	0.031	0
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	22.9	22.9	0
6	Аймаг дундын отрын бэлчээр	586.2	691.4	105.2
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110.9	110.9	0
8	Газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0
9	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0


Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 229 дугаар тогтоолоор Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт 105.2 мянган га газрыг баруун бүсийн аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсны дагуу өөрчлөлтийг ГТ-4 тайланд тусгав.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хил зааг тогтоох тухай 50 дугаар тогтоолоор Говь-Алтай аймгийн Халиун, Цээл сумдын нутгийг дамнан орших Хар Азаргын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хэрэгцээний газарт бэлчээрийн газраас 192.5 мянган га газрыг авсны дагуу ГТ-4 тайланд өөрчлөлтийг оруулав.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хил зааг тогтоох тухай 50 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын нутагт орших Хүрээмандал уул, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Мөнххаан сумдын нутгийг дамнан орших Баянцагааны тал, Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Дархан уул, мөн аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Хэрлэн Тооно уул, Увс аймгийн Хяргас сумын нутагт орших Булган хангай уул, Чингэлтэй хайрхан уул орчмын байгалийн нөөц газрын хилийн заагийг 1 дүгээр, Увс аймгийн Давст сумын нутагт орших Мөнгөт Цахир уул, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Дарханхаан уул, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Хангал нуур, мөн аймгийн Батширээт сумын нутагт орших Биндэръяа хан уулын байгалийн дурсгалт газрын хилийн заагийг тогтоосон боловч тус газруудад экспликаци хийгдээгүй байгаа тул ГТ-4 тайланд тусгах боломжгүй байна.

2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

2014 онд улсын хэмжээнд нийт 5658111.8 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 44650.7 га-г өмчилж, 5420028.1 га-г эзэмшиж, 174174.6 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага 19258.4 га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.




Зураг 2.3.1. 2014 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /га-гаар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2013 онтой харьцуулбал 121742.3 га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.




Зураг 2.3.2. Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2013 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар 44650,7 га болж 4231,7 га-аар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газар 5420028,1 га болж 115230,3 га-аар /Зураг 2.3.4/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар 19258,4 га болж 3685,7 га-гаар /Зураг 2.3.5/ тус тус өссөн бол иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар 174174,6 га болж 1405,3 га-гаар /Зураг 2.3.6/ буурсан дүнтэй байна.




Зураг 2.3.3. Газар өмчлөгч /га–гаар/



Зураг 2.3.4. Газар эзэмшигч /га–гаар/




Зураг 2.3.5. Бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /га–гаар/



Зураг 2.3.6. Газар ашиглагч /га–гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт 1206985.4 га, хот тосгон, бусад суурины газарт 458844.2 га, зам, шугам сүлжээний газарт 166307.8 га, ойн сан бүхий газарт 666854.0 га, усны сан бүхий газарт 87416.1 га, улсын тусгай хэрэгцээний газарт 3071704.2 га газар өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.



Зураг 2.3.7. Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/

Хүснэгт 2.3.1. Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2013	2014	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	51.4	48.1	-3.3
		эзэмшигч	1152870.4	1192745.3	39874.9
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7266.1	7377.3	111.2
		ашиглагч	8278.0	6814.7	-1463.3
		нийт	1168465.9	1206985.4	38519.5
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	40367.7	44602.6	4234.9
		эзэмшигч	287713.2	341449.8	53736.6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	5265.9	5446.8	180.9
		ашиглагч	68747.0	67345.0	-1402.0
		нийт	402093.8	458844.2	56750.4
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	140139.2	150948.1	10808.9
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	2714.8	6108.4	3393.6
		ашиглагч	7950.5	9251.3	1300.8
		нийт	150804.5	166307.8	15503.3
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	672277.0	666787.5	-5489.5
		ашиглагч	46.5	66.5	20.0
		нийт	672323.5	666854.0	-5469.5
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	82120.1	85193.7	3073.6
		ашиглагч	2083.3	2222.5	139.2
		нийт	84203.4	87416.1	3212.7
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	2969678.0	2982903.7	13225.7
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	325.9	325.9	0.0
		ашиглагч	88474.6	88474.6	0.0
		нийт	3058478.5	3071704.2	13225.7


Тус тайлангаар улсын хэмжээнд нийт 803217 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх онохоос нийт дүнгээрээ 81547-аар өссөн байна /Зураг 2.4.1/.

2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/




Зураг 2.4.1. Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/


Тайлант онд газар өмчлөгч 418671, эзэмшигч 382919, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 921, газар ашиглагч 706 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.




Зураг 2.4.2. Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид /эзлэх хувь/




Зураг 2.4.3. Газар өмчлөгч /тоогоор/



Зураг 2.4.4. Газар эзэмшигч /тоогоор/




Зураг 2.4.5. Бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/



Зураг 2.4.6. Газар ашиглагч /тоогоор/

Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт 172025, хот тосгон, бусад суурины газарт 625165, зам, шугам сүлжээний газарт 1703, ойн сан бүхий газарт 2627, усны сан бүхий газарт 47, улсын тусгай хэрэгцээний газарт 1650 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.



- Хот тосгон, бусад суурины газар
- Хөдөө аж ахуйн газар
- Улсын тусгай хэрэгцээний газар
- Усны сан бүхий газар
- Ойн сан бүхий газар
- Зам шугам сүлжээний газар

Зураг 2.4.7. Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /эзлэх хувь/


Хүснэгт 2.4.1. Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2013	2014	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	82	52	-30
		эзэмшигч	168326	171869	3543
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	53	68	15
		ашиглагч	37	36	-1
		нийт	168498	172025	3527
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	371896	418619	46723
		эзэмшигч	174490	205823	31333
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	177	166	-11
		ашиглагч	503	557	54
		нийт	547066	625165	78099
3	Зам, шугам сүлжээний газар	эзэмшигч	1473	1597	124
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	6	11	5
		ашиглагч	63	95	32
		нийт	1542	1703	161
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	3016	2623	-393
		ашиглагч	3	4	1
		нийт	3019	2627	-392
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	36	41	5
		ашиглагч	3	6	3
		нийт	39	47	8
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	819	966	147
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	676	676	0
		ашиглагч	11	8	-3
		нийт	1506	1650	144

2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ–6/

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон, хуурай бүс нутагт оршдог манай оронд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхлагдал, тариалангийн хөрсний үржил шимийн бууралт, ойн түймэр, хортон шавьж, модны замбараагүй хэрэглээ, уул уурхайн зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтол, цөлжилт ихээхэн явагдаж байна. Энэхүү доройтлыг “газарт учруулсан хохирол” гэсэн томъёололд хамааруулан хохирлын хэмжээг дэлгэрэнгүй үзүүлэлт /ГТ–6 маягт/–үүдээр хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

Улсын хэмжээнд газарт учруулсан хохирлын тайланг ГТ–6 маягтын дагуу дэлгэрэнгүй байдлаар хүлээн авч нэгтгэхэд улсын хэмжээнд тариалангийн 172112.3 га, бэлчээр ба бусад өвслөг ургамалт газарт 9006534.3 га, хот тосгон, бусад суурин газарт 15945.8 га, ойн сан бүхий газарт 188630.9 га, усны сан бүхий газарт 488.2 га, ухагдаж эвдэрсэн газрын хэмжээ 6832.6 га, нийт 9390544.1 га талбай хохирсон байна /Зураг 2.5.1/.



Зураг 2.5.1: Газарт учруулсан хохирлын зураг /аймгаар/


Газарт учруулсан хохирлыг газрын нэгдмэл сангийн ангиллын газруудаар авч үзэхэд дараах байдалтай байна.

Тариалангийн газар

Тариалангийн талбай салхины эвдрэлд орох, үржил шим нь буурах, мэрэгчид, хортон шавьжид нэрвэгдэх зэргээр манай орны нийт хөрсний ялзмагийн агууламж буурч ургамалд ашигтай тэжээлийн химийн элементүүд багасаж байна.

Тариалангийн газрын хохирол, доройтлыг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шимийн бууралттай, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон болон бусад гэсэн үзүүлэлтүүдээр ангилан гаргахад улсын хэмжээнд нийт 172.1 мян.га буюу урьд оныхоос 133.0 мян.га буюу 77.2 хувиар нэмэгджээ.

Үүнээс хамгийн их 62.9 хувь буюу 108272.7 га талбайн үржил шим буурсан, 36.01 хувь буюу 61987.5 га талбай мэрэгчид, хортон шавьжинд идэгдсэн, 0.50 хувь буюу 876 га салхины эвдрэлтэй, 0.44 хувь буюу 761.6 га усны эвдрэлтэй, 0.02 хувь буюу 37.8 га талбайн хөрс бохирдсон, 131.3 га талбай бусад төрлийн хохирол тус тус учирсан байна /Зураг 2.5.2/.



Зураг 2.5.2: Тариалангийн газарт учирсан хохирлын төрөл /хувь/

Тариалангийн газарт учирсан хохирлын хэмжээ нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайтай харьцуулахад 1.83 хувь нь болж байна.

Тариалангийн газарт учирсан хохирлын хэмжээ, төрөл нь бүс нутгуудад ялгаатай байгаа боловч өмнөх жилээс буурсан нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, “Атрын-III аян”-ы хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үр дүн гэж үзэж болохоор байна. Сүүлийн 20-иод жил уналтад орсон газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, атаршсан талбайн хэмжээ буурч, тариалангийн газрын ашиглалт сайжирсан нь дээрхи мэдээнээс харагдаж байна.


Газар тариалангийн гол бус болох Төв, Хөвсгөл, Завхан аймгууд хамгийн их буюу 20.6–107.1 мян.га талбайд хохирол учирсан байна. Тариалангийн талбайн хохиролын гол шалтгаан нь үржил шимийн бууралт, мэрэгчид, хортон шавьжинд нэрвэгдэх байдал болж байна.

Бэлчээрийн газар

Бэлчээрт учирсан хохирлын дүн мэдээг улсын хэмжээнд авч үзэхэд 2014 оны байдлаар бэлчээр ба өвслөг ургамалтай газарт 9.0 сая га бэлчээр хохиролд өртсөн нь газарт учирсан нийт хохирлын дийлэнх буюу 95.9 хувийг эзэлж байна.

Бэлчээрт учирсан хохирлыг төрлүүдээр нь авч үзвэл 21.9 хувь буюу 1.9 сая га талхлагдсан, 0.2 хувь буюу 21 мян.га нь салхи, усны эвдрэлд орсон, 3.5 хувь буюу 320.6 мян.га элсний нүүлтэд өртсөн, 42.3 хувь буюу 3.8 сая.га мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, 31.4 хувь буюу 2.8 сая.га цөлжсөн, 0.5 хувь буюу 45.0 мян.га ашигт малтмалын олборлолтоос бохирдсон байна.

Бэлчээрийн газарт учирсан хохирлын хэмжээг доорхи графикаар үзүүлэв /Зураг 2.5.3/.



Зураг 2.5.3: Бэлчээрт учирсан хохирлын харьцуулалт /оноор/


Бэлчээрийн хохирлын хэмжээг 2013 онтой харьцуулахад салхи, усны эвдрэл 10.4 мян.га, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн 1282.1 мян.га, талхлагдсан 105 мян.га, элсний нүүлтэд орсон талбай 79.9 мян.га-гаар тус тус өссөн, харин цөлжсөн газар 1273.5 га, ашигт малтмалын олборлолтод өртсөн талбай 2.3 мян.га-гаар буурсан мэдээ гарлаа.

Талхлагдсан бэлчээрийн хэмжээ бууралтанд өнгөрсөн жилийн хур тунадасны хэмжээ (нийт нутгийн 80 орчим хувь нь зуншлага сайтай) нөлөөлжээ. Энэ оны бэлчээрт учирсан хохирлын хамгийн их хувийг Дундговь аймаг 1.6 сая га, Дорнод аймаг 1.5 сая га, Сүхбаатар аймаг 1.3 сая га талбай тус тус эзлэж байна.

Хот тосгон, бусад суурин газар

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа суурьшил нь нэг талаас газрын гадаргыг ургамалан бүрхэвчгүй болгох, элсний нүүлтийг нэмэгдүүлэх зэргээр түүний орчны доройтлыг ихэсгэж байна. Хөрсөн дээр ургамалан бүрхэвчгүй болоход элсний нүүлт хөдөлгөөн идэвхиждэг. Мөн үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, иргэн, айл өрхийн ахуйн хэрэглээнээс хог хаягдал, бохирдуулагч бодис зориулалтын бус байгууламжаар дамжин агаар мандал, усан орчин, хөрс, газрын хэвлий, орчныг бохирдуулж байна.

Хот тосгон,бусад суурин газарт нийт 15945.8 га талбайд хохирол учирснаас ургамалан бүрхэвчгүй болсон 42.9 хувь буюу 6841.2 га элсний нүүлтэд орсон 5.8 хувь буюу 934.7 га үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 0.3 хувь буюу 55.2 га, ахуйн хог хаягдлаар бохирдсон 49.7 хувь буюу 7927 га, бусад төрлийн хохирол учирсан 1.1 хувь буюу 187.1га газар тус тус бүртгэгджээ /Зураг 2.5.4/.



Зураг 2.5.4: Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, /аймгуудаар/

Дээрх зургаас харахад Говь алтай, Өмнөговь, Сэлэнгэ, Завхан, Говьсүмбэр аймгуудын хот тосгон, бусад суурины газар хохиролд ихээхэн өртсөн байна. Дийлэнх аймгуудад ахуйн хог хаягдлаар бохирдсон гэж бүртгэгдсэн бол Говь–Алтай аймагт ургамалан бүрхэвчгүй болсон хот суурины талбай 5722 га байгаа нь хамгийн их нь юм.

Ойн сан бүхий газар


Манай орны ойн сангийн газарт түймэр ихээр гарах, өвчин, хөнөөлт шавьжинд нэрвэгдэх, ашигт малтмалын олборлолтод өртөх, зөвшөөрөлгүй мод огтлох зэргээр ойн экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж доройтолд орсоор байна.

Ойн сан бүхий газарт 188630.9 га талбайд хохирол учирснаас түймэрт нэрвэгдсэн 17.5 хувь буюу 33068.6 га, өвчин, хортон шавьжид идэгдсэн 73.4 хувь буюу 138635 га, ашигт малтмалын олборлолтонд өртсөн 0.007 хувь буюу 13.5 га, мод бут, сөөг, загийг устгасан 8.9 хувь буюу 16903.4 га газар тус тус байна.

Хүснэгт 2.5.1: Ойн сан бүхий газарт учирсан хохирлын хэмжээ /мян.га/

Он	Түймэрт нэрвэгдсэн	Өвчин, хортон шавьжид идэгдсэн	Ашигт малтмалын олборлолтод өртсөн	Мод бут, сөөг, загийг устгасан
2009	448,2	255,5	0,04	130,0
2010	67,4	177,1	0,04	131,2
2011	55,5	107,5	111,6	129,8
2012	217,7	63,1	0,04	147,7
2013	37,3	85,8	19,1	85,8
2014	33,0	138,6	0,01	16,9

Дийлэнх хохирлын 73.4 хувь нь өвчин хортон, шавьжид идэгдсэн, 17.5 хувь нь түймэрт нэрвэгдсэн 8.9 хувь нь мод, бут, сөөг, загийг нь устгаснаас үүссэн хохирол байна. 2014 онд ойн сан бүхий газарт учирсан хохирлын хэмжээг 2013 оныхтой харьцуулахад өвчин, хортон шавьжид идэгдсэн ойн талбай 52.2 мян.га–аар нэмэгдсэн бол түймэрт нэрвэгдсэн 4.3 мян.га–гаар, мод бут, сөөг загийг нь устгасан ой 17.9 мян.га–гаар, ашигт малтмалын олборлолтод өртсөн ойн сангийн талбай 19.09 га–гаар тус тус буурчээ./Зураг 2.5.5/.



Зураг 2.5.5: Ойн сангийн газарт учирсан хохирлын төрөл /хувь/

Түймэрт шатсан ойгоор Хэнтий, Дорнод, Булган, Увс, Төв аймгууд, өвчин хортон шавьжид идэгдсэн ойн талбайгаараа Архангай, Хэнтий, Булган, Завхан, Увс, Сэлэнгэ бусад аймгуудаас их хэмжээтэй байна.

Усны сан бүхий газар

Усны сан бүхий газарт нийт 488.2 га хохиролд өртсөнөөс гадаргын болон гүний усны бохирдол 65.7 хувь буюу 321.1 га, ашигт малтмалын олборлолтоос хохиролд өртсөн эрэг хавийн газар 17.3 хувь буюу 84.9 га, бусад шалтгаанаар хохирсон 16.83 хувь буюу 82.2 га тус тус газар бүртгэгджээ.

Өмнөх оны дүнтэй харьцуулж үзэхэд усны сангийн талбайд учирсан хохирол нийт 45.7 га-гаар буурсан байна. Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, болон бусад шалтгаанаар хохиролд орсон газар Говь-Алтай, Дархан-Уул, Завхан, Сэлэнгэ аймаг хамгийн их өртсөн байна.

Ухагдаж эвдэрсэн газар

Хэдийгээр уул уурхайн салбар Монгол улсын хөгжилд чухал ач холбогдолтой ч газрын доройтлыг бий болгож байгаа үндсэн хүчин зүйлүүдийн нэг юм. Ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, авто зам тавих, геологийн эрэл хайгуул хийх, барилга байгууламж барих явцад байгалийн хөрсийг хуулах, шороон далан, овоолго бий болгох, шуудуу татах зэргээр газрын төрх байдлыг өөрчилж техникийн гаралтай хөрсний эвдрэл ихээр бий болгож байна. Үүний зэрэгцээ хүнд машин механизмаар эмх замбараагүй олон зам гаргаж, тоос бужигнуулан орчныг их хэмжээгээр доройтуулж, нөхөн сэргээлтийн ажлууд хангалттай хэмжээнд хийгдэхгүй байгаа нь доорхи мэдээнээс харагдаж байна.


Ухагдаж эвдэрсэн газар нийт 6832.6 га талбайг эзлэж байгаагаас геологийн эрэл хайгуулын ажлаас 1.6 хувь буюу 114.4 га, ашигт малтмалын олборлолтоос 82.7 хувь буюу 5655.4 га, батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас 0.5 хувь буюу 36.2 га, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 2.8 хувь буюу 195.4 га, зам тээвэр холбооны барилга засвар үйлчилгээний ажлаас 12.1 хувь буюу 831.3 га талбай тус тус эвдэрсэн байна.

Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолтоос эвдэрсэн газар Сэлэнгэ аймагт хамгийн их буюу 22161 га, Төв аймагт 1711.8 га, Өмнөговь аймагт 746.5 га, Дархан-Уул аймагт 492.1 га, Говь-Алтайн аймагт 293.5 га байна.

Газар хамгаалах арга хэмжээг авсан газрыг газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Тариалангийн газар


Тариалангийн газрын хувьд нийт 150534.4 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас 1859.7 га–д олон наст тариалж, 47677.6 га газрыг зурваслан, 830.4 га газрыг ойн зурвасаар хамгаалан, 26182.4 га–г химийн бордоогоор бордсон, 22244.9 га–г шим ба эрдэс бордоогоор бордож, 51739.4 га талбайн хортон шавьж мэрэгчдийг устгасан байна. /Зураг 2.6.3/.



Зураг 2.6.3: Тариалангийн газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Бэлчээрийн газар


Бэлчээр ба өвслөг ургамалтай газрын хувьд нийт 3011.1 мян.га талбайг хамгаалсанаас элсний нүүлтээс хамгаалсан талбай 174.5 га, тордон сайжруулсан 17003.2 га, хортон мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн 1023042.6 га, хог хаягдлаас цэвэрлэсэн 23779.5 га, даацыг нь тохируулсан 410774.3 га, ашиглалтаас чөлөөлсөн 145072.1 га, сэлгэж ашигласан 1391282.2 га талбай байна. /Зураг 2.6.4/



Зураг 2.6.4: Бэлчээр ба бусад өвслөг ургамалт газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрын хувьд нийт 14036.1 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас хөрсжүүлэн зүлэгжүүлсэн 40.4 га, мод бут сөөг тарьсан 2071.0 га, далан хаалтаар хамгаалсан 47.3 га, нүх жалгыг тэгшилж янзалсан 321.3 га, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн 11560.6 га, элсний нүүлтээс хамгаалсан 40.7 га талбай тус тус эзлэж байна /Зураг 2.6.5/.



Зураг 2.6.5: Хот, тосгон бусад суурины газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газарт нийт 41967,9 га талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авчээ. Тухайлбал 3912.8 га ойд цэвэрлэгээ хийж, 32864.6 га талбайд ойн өвчин, хортон шавьжтай тэмцэж, 5190.6 га талбайд мод, бут, сөөг шинээр тарьж, нөхөн суулгалт хийсэн байна.

Усан сан бүхий газар

Усны сан бүхий газарт нийт 545.5 га талбайг хамгаалжээ. Ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээг 343.1 га талбайд, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэж хамгаалах арга хэмжээ авсан 183.2 га, усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээг 19.2 га талбайд тус тус авчээ.

Уурхайн эдэлбэр газар

Геологийн эрэл хайгуул, уул уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн 5430.2 га газарт хамгаалалтын арга хэмжээ авснаас нийт 1771.0 га талбайг эргүүлэн дарж булсан, 3647.2 га дарж булсан талбайг хөрсжүүлж ургамалжуулсан /биологийн нөхөн сэргээлт хийсэн/, 12.0 га эвдрэлд өртсөн голын эрэг хавийн газрыг сэргээсэн байна.

Улсын хэмжээнд Дорнод аймагт 3008 га, Өмнөговь аймагт 677.1 га, Орхон аймагт 372.4 га, Баян-өлгий 271.3 га, Ховд аймагт 249.6 га талбайг тус тус хамгаалах арга хэмжээ авсан нь эхний байруудад орж байна. Архангай, Увс, Завхан аймгуудад ухагдаж эвдэрсэн газрыг дарж булах, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай байхгүй байна.

Газар хамгаалах арга хэмжээний дийлэнх буюу 93.4 хувь нь бэлчээр ба бусад өвслөг ургамалтай газарт байгаа бөгөөд сэлгэн ашиглах, даацыг тохируулах, хортон мэрэгчдийн хөнөөлтэй тэмцэх, ашиглалтаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн дагуу газрын төлбөрийг ногдуулж, төвлөрүүлж байна. Энэ хугацаанд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт нийт 338 тэрбум 205 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн дүнтэй байна.


Монгол Улсын хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч иргэн хуулийн этгээдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн хувь жил ирэх бүр өсөж байна /Хүснэгт 2.7.1/.

Хүснэгт 2.7.1: Газрын төлбөрийн гүйцэтгэл

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл / сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1,919.6	1,524.5	80
1999	2,678.6	1,764.2	66
2000	3,221.5	2,895.0	90
2001	4,673.6	5,401.9	116
2002	5,570.7	6,163.1	110
2003	7,303.4	7,962.0	109
2004	11,840	11,795.2	99
2005	13,867.6	14,045.2	101
2006	14,323.0	15,780.7	110
2007	19,786.8	20,093.7	102
2008	24,790.4	25,543.4	102
2009	28,006.6	29,472.4	105
2010	29,311.7	30,448.6	104
2011	31,280.7	33,556.8	107
2012	39,031.3	43,623.2	112
2013	37,912.0	43,185.1	114
2014	42,326.9	44,950.9	106
Нийт	317,844.40	338,205.90	106

2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ /МАЯГТ ГТ-8/

2014 онд улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт 44 тэрбум 950.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөөг 106%-аар биелүүлсэн ба өмнөх оны орлоготой харьцуулхад 1.8 тэр бум төгрөгөөр өссөн дүнтэй байна /Зураг 2.7.1/.



Зураг 2.7.1. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /оноор/

2014 оны газрын төлбөрийн орлогыг аймаг тус бүрээр гаргавал Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Орхон зэрэг аймгууд газрын төлбөрийг 114–207 хувийн гүйцэтгэлээр давуулан биелүүлсэн дүнтэй байх ба Дорноговь, Дундговь, Хөвсгөл, Ховд аймгууд 70–80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дээр дурдсанаас бусад аймгуудын хувьд газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлт 101–107 хувийн биелэлттэй байна.

Улсын хэмжээнд 2013 оны үлдэгдэл газрын төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн, ашигт малтмалын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан компаниуд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болсон, уул уурхайн ашиглалтын болон том хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тоо өмнөх жилээс нэмэгдсэн зэрэг нь 2014 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл давж биелэхэд нөлөөлсөн байна. Тухайлбал:

Баянхонгор аймгийн хэмжээнд газрын төлбөрийг 7 сум 26–82,6% биелүүлээгүй ба 2 сум 97–99% биелүүлсэн, 11 сум 100–166 хувиар биелүүлснээр аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлого 99,7% биелсэн байна.

Мөн Жаргалант, Бууцагаан, Заг, Эрдэнэцогт, Богд, Баян–Овоо зэрэг сумдуудад 2014 оны газрын төлбөрийн төлөвлөгөө 120,0–150,0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 100–266 хувиар давуулан биелүүлсэн нь аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлого өндөр хувьтай биелсэн байна.

Говь–Алтай аймгийн хувьд 2014 оны байдлаар 108921.5 мянган төгрөг төлөвлөснөөс 143901.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөгөөг 133 %-иар биелүүлсэн дүнтэй байна. Аймгийн хэмжээнд 2014 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх онд оруулсан орлогоос 59985.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Архангай аймгийн хэмжээнд газар эзэмшиж, ашиглаж буй 13985 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглуулах, эзэмшүүлэх гэрээг байгуулж, газрын төлбөр ногдуулан хураах ажлыг зохион байгуулан ажилласнаар 2014 онд газрын төлбөрөөс 29721.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж биелэлт 94,0 хувьтай байна.

Булган аймаг 2014 онд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газрын төлбөрт нийтдээ 123,855,584 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээс 122,415,344 мянган төгрөгийг төвлөрүүлж 98,8%-ийн биелэлттэй байна. Дуудлага худалдаанд 70,0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 92,579,464 мянган төгрөг төвлөрч 132,2%, нийт 193,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 214,9 сая төгрөг төвлөрч 110,9–иар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Дархан–Уул аймаг нь Газрын төлбөрийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх, орон нутгийн төсвийг тогтвортой бүрдүүлэх зорилгоор 2014 оны 09 дүгээр сараас эхлэн “Газрын төлбөрийн 3 сарын аян”–ыг орон нутгийн телевиз, радио, аймгийн Татварын хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс болон бусад төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж газрын төлбөрийг 2014 онд бүрэн барагдуулж 603,1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Дорнод аймаг нь “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль” болон Дорнод аймгийн ИТХ–ын 2003 оны 7 дугаар хуралдаанаас баталсан “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний итгэлцүүр батлах тухай” 03 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан 26236 иргэний газрын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 16.483,5 мянган төгрөг ногдуулснаас тайлангийн хугацаанд 2.187,1 сая төгрөг буюу 13,2 % –ийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант оны байдлаар 260.290,9 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн ба 2014 оны газрын төлбөрийн төлөвлөгөө жилийн эцсийн байдлаар 102.5 % биелсэн дүнтэй байна.

Завхан аймаг 2014 оны байдлаар аймгийн хэмжээнд эзэмших, өмчлөх, ашиглах эрх үүссэн нийт 17763 нэгж талбарт 76.600 мянган төгрөгийг ногдуулан Аймгийн татварын хэлтсийн дүнгээр 88 сая төгрөг төлөвлөсөнөөс 181792.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нь орлогын гүйцэтгэл 206.5 хувийн биелэлттэй давуулан биелүүлсэн байна.

Орхон аймаг 2014 онд газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 9376,61 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд газрын төлбөр барагдуулах, газар эзэмших, ашиглах гэрээ дүгнэх ажлыг холбогдох байгуулагуудтай хамтран бүтэн жилийн туршид зохион байгуулсны үр дүнд орон нутгийн төсөвт газрын төлбөрийн орлогоос 10518,15 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 112,3 хувиар биелсэн байна.

Завхан аймаг 2014 оны байдлаар аймгийн хэмжээнд эзэмших, өмчлөх, ашиглах эрх үүссэн нийт 17763 нэгж талбарт 76.600 мянган төгрөгийг ногдуулан аймгийн татварын хэлтсийн дүнгээр 88 сая төгрөг төлөвлөсөнөөс ахуйн зориулалтаар эзэмшиж буй 390.5 га газраас 6.1 сая, аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй 320.1 га газраас 21.4 сая, ХАА-н зориулалтаар эзэмшиж буй 2030.2 га газраас 38.346 мянга, уул уурхайн зориулалтаар ашиглаж буй 2883.5 га газраас 9.054 мянга, аймгийн хэмжээний газар өмчлөгч 6120 иргэн, аж ахуйн нэгжээс 1.7 мянган төгрөгийн ногдуулалт хийгдэж 181792.6 мянган төгрөг төвлөрүүлсэн нь орлогын гүйцэтгэл 206.5 хувийн биелэлттэй давуулан биелүүлсэн байна.

Өвөрхангай аймаг газар эзэмшигч, ашиглагч бүрээр газрын төлбөрийг ногдуулж газрын төлбөрийг 98555.16 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс аймгийн төсөвт 104761.59 мянган төгрөг орж 106.3%-ийн гүйцэтгэлтэй байна. 2014 онд уул уурхайн зарим газар эзэмшигч нарын эрх цуцлагдсан учир урьд оны гүйцэтгэлээс бага зэрэг буурсан дүнтэй байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2014 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт 3078909.1 мянган төгрөг төвлөрүүлэхээр ногдуулалт хийж ажилласан бөгөөд 2014 онд шинээр 25 газар эзэмшигч, ашиглагчид 97359.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулж, 2014 онд 3188145.5 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн ба 103.5%-иар биелсэн дүнтэй байна.

Сүхбаатар аймгийн хувьд газрын төлбөрийн орлогоос 159000.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс оны эцэст төсөвт 161957.0 мянган төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө аймгийн хэмжээнд 101.8 хувиар давж биелсэн байна. Уулбаян сумын нутагт уурхайн нээгдсэн, мөн Мөнххаан суманд газар тариалан эрхлэх аж ахуйн нэгж шинээр бүртгүүлсэн эдгээрээс газрын төлбөрийг жилээр тооцож ногдуулснаас орлогын төлөвлөгөө өндөр хувиар давж биелсэн харагдаж байна. Уул уурхайн газруудын зам ашигласны гэрээг сумдын Засаг дарга нар тогтмол хийж байгаа тул уг төлбөр хангалттай төлөгдсөн нь сумдын газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд ихээр нөлөөлсөн байна.

